



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

(2017 оны жилийн эцсийн тайлан)

2017-12-25
Улаанбаатар хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ – ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

(Жилийн эцсийн тайлан)

2017.12.25

Улаанбаатар хот

Хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		Хариуцах нэгж, албан тушаалтны нэр	Биелэлтийн талаарх тайлан, мэдээлэл, Хэрэгжилтийн үнэлгээ
	Арга хэмжээний шалгуур үзүүлэлт (тоо, чанар хугацаа)-ийн хүрэх түвшин	Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин		
1	2	3	4	5
Нэг. “Төрийн өмчийн талаар хууль тогтоомж, бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах удирдлага, зохион байгуулалтаар хангах” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:				
ХӨТӨЛБӨР I				
“Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль, эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах” хөтөлбөрийн хүрээнд:				
Арга хэмжээ 1.1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга) боловсруулах	<ul style="list-style-type: none"> - Хуулийн төслийг боловсруулах шаардлага, үндэслэлийг тодорхойлох; - Хуулийн төслийг боловсруулах; - Хуулийн төсөлд санал авах ажлыг зохион байгуулж, хэлэлцүүлэг хийх; - Хуулийн төслийг ЗГХЭГ-т хүргүүлж, УИХ-ын Тамгын газар, Байнгын хороодод уламжлуулах арга хэмжээ авах; - I-II улиралд. 	Хууль эрх зүйн орчин боловсронгуй болно.	Захиргаа, хууль зүйн хэлтэс (цаашид “ЗХЗХ” гэх), Ажлын хэсэг	Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 126 дугаар тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага, аргачлалын дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, холбогдох баримт, материалын хамт 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А-1/2650 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэв. Энэхүү хууль тогтоомжийн төслийг боловсруулах хүрээнд төрийн өмчийн талаарх 37 улс орнуудын хууль, эрх зүйн зохицуулалтын судалгаа хийж, төслийг 21 аймгийн Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөл болох нийт 134 хүнд танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулан, холбогдох байгууллагаас санал авсан. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хүрээнд мөн холбогдох 22 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулсан. ("Бүрэн хэрэгжсэн" - 100%)
Арга хэмжээ 1.2.2. Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах,	- Хувьчлах, өөрчлөн байгуулах аж ахуйн нэгжийн судалгаа	Төрийн өмчийн ашиглалт, төрийн өмчит	Бодлого, төлөвлөлт, удирдлагын	“Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл, танилцуулгыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага, аргачлалын дагуу боловсруулж, ТӨБЗГ-ын 2017 оны

<p>өөрчлөн үндсэн батлуулах байгуулах чиглэлийг</p>	<p>гаргах; - Танилцуулга бэлтгэж, удирдлага, газрын хуралдаанд танилцуулах; - Үндсэн чиглэлийг Засгийн газар хүргүүлж, УИХ-аар батлуулах арга хэмжээ авах; - I улиралд.</p>	<p>хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэнэ.</p>	<p>хэлтэс (цаашид “БТУХ” гэх)</p>	<p>02 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Уг хуралдааны 03 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас чиглэл авахаар үндсэн чиглэлийн төсөл, саналыг 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А-1/684 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Үндсэн чиглэлийн төсөлд салбарын 11 яамнаас албан бичгээр авсан санал болон ТӨБЗГ-ын саналыг нэгтгэн тусгасан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 126 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт “Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага, аргачлалын дагуу боловсруулах үүрэг өгсний дагуу үндсэн чиглэлийг батлах тогтоолын хэрэгцээ шаардлагыг тандан судалж, үзэл баримтлалыг дахин боловсруулан 2017 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А-2/2021 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцүүлж, Засгийн газрын хуралдааны 36 дугаар тэмдэглэлээр холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нартай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Төсвийн ерөнхийлөн захирагч нараас санал авч нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлээд байна. “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга мөн “Татан буулгах хуулийн этгээдийн тухай”, “Төсөвт үйлдвэрийн газар болгох тухай”, “Өөрчлөн зохион байгуулах хуулийн этгээдийн тухай” саналыг ТӨБЗГ-ын хуралдаанаар тус тус 2-3 удаа хэлэлцүүлж, нэгтгэн боловсруулсан төслийг 11 дүгээр сард ЗГХЭГ-ын албан хэрэгцээнд хүргүүлсэн. (“Хэрэгжих шатанд” - 70%)</p>
<p>Арга хэмжээ 1.3.3. 2017-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт батлуулах</p>	<p>- 2017-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт боловсруулах; - Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулах; - Засгийн газрын тогтоолоор батлуулах</p>	<p>Төрийн өмчийн ашиглалт, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэнэ.</p>	<p>БТУХ</p>	<p>УИХ-ын 2015 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, 2016 оны “УИХ-ын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай” 64 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “2017 онд хувьчлах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт”-ыг гарган Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгын хамт ТӨБЗГ-ын 2017 оны А-1/659, А-1/2166 дугаар албан бичгээр тус тус ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэлээр холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нартай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар дахин хэлэлцүүлэх шийдвэр гарсан. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, удирдлага менежментийг оновчтой болгох</p>

	<p>арга хэмжээ авах;</p> <ul style="list-style-type: none"> - I улиралд. 			<p>чиглэлээр татан буулгах, нэгтгэн зохион байгуулах, төсөвт үйлдвэрийн газар болгох, компанийн хэлбэрт шилжүүлэх, салбарын яамнаас үйл ажиллагааг нь эрчимжүүлэх шаардлагатай хуулийн этгээдийн жагсаалт, танилцуулгыг боловсруулан ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Авто замын засвар, арчлалтын компаниудын үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, авто замын хариуцах чиглэл, хэмжээг оновчтой болгох, 20 хуулийн этгээдийг нэгтгэн, нэгдмэл удирдлагаар хангах замаар компанийн засаглалыг сайжруулан, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зам засвар, арчлалтын чанарыг дээшлүүлэх зорилгоор өөрчлөн зохион байгуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлсэн.</p> <p>“Төрийн өмчөөс хувьчилж үл болох аж ахуйн нэгж болон эд хөрөнгийн жагсаалт батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл, танилцуулга болон холбогдох материалыг боловсруулж, ТӨБЗГ-ын 24 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох хууль, журмын дагуу Засгийн газарт хүргүүлэхээр шийдвэрлэсэн. (“Хэрэгжих шатанд” - 70%)</p>
<p>Арга хэмжээ 1.4.4. “Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч томилон ажиллуулах журам”-ын төслийг боловсруулж, батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Журмын төслийг боловсруулах; - Журмын төсөлд холбогдох этгээдээс санал авах; - Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах; - Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; - Байгууллагын цахим хуудас www.pcsp.gov.mn –д байршуулах; - I улиралд. 	<p>Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажилд ахиц гарна.</p>	<p>БТУХ</p>	<p>“Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч томилон ажиллуулах журам”-ын төсөл боловсруулсан хэдий ч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсаны дараа нэг мөр шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хувьчлах аж ахуйн нэгж, үл хөдлөх хөрөнгө дээр итгэмжлэгдсэн төлөөлөгч томилон ажиллуулж, 2017 онд хувьчлагдсан “Оргил рашаан сувилал” ТӨХК, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн “Болор” амралтын газар, “Архангай АЗЗА” ТӨХК-ийн “Замчин” зочид буудлын барилга байгууламж, Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга зэргийг амжилттай хувьчилсан. (“Хэрэгжих шатанд” - 70%)</p>
<p>Арга хэмжээ 1.5.5. “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах нийтлэг журам” боловсруулж батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Журмын төслийг боловсруулах; - Журмын төсөлд холбогдох этгээдээс санал авах; - Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах; - Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; - Байгууллагын цахим хуудас www.pcsp.gov.mn –д байршуулах; - I сард. 	<p>Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн хүрээнд оновчтой зохион байгуулалтаар хангагдана.</p>	<p>БТУХ</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилэн найруулгын төсөл батлагдах хүртэл “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах нийтлэг журам” боловсруулах ажил хойшлогдсон.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаагаа явуулж байна. (“Хэрэгжих шатанд” - 70%)</p>

<p>Арга хэмжээ 1.6.6. “Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх этгээдэд удирдамж болон заавар өгөх, төлөөлөл хэрэгжүүлсэн байдлыг дүгнэх журам” боловсруулж батлуулах, мөрдүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Журмын төслийг боловсруулах; - Журмын төсөлд холбогдох этгээдээс санал авах; - Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах; - Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; - Байгууллагын цахим хуудас www.pcsp.gov.mn –д байршуулах; - I сард. 	<p>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ажлын үр дүнд ахиц гарч, тухайн хуулийн этгээдийн үр ашигтай ажиллагаа сайжирна.</p>	<p>БТУХ</p>	<p>“Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх этгээдэд удирдамж болон заавар өгөх, төлөөлөл хэрэгжүүлсэн байдлыг дүгнэх журам”-ын төслийг боловсруулсан боловч Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага, аргачлалын дагуу боловсруулах үүргийн дагуу дахин боловсруулж байна. (“Хэрэгжээгүй” - 0%)</p>
<p>Арга хэмжээ 1.7.7. “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг тэнцвэржүүлсэн үнэлгээний аргаар дүгнэх, урамшуулал олгох журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Журмын төслийг боловсруулах; - Журмын төсөлд холбогдох этгээдээс санал авах; - Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах; - Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; - Байгууллагын цахим хуудас www.pcsp.gov.mn –д байршуулах; - I сард. 	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн сайжирна.</p>	<p>БТУХ</p>	<p>“Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын төслийг боловсруулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2017 оны 90 дүгээр тогтоолоор баталсан. Энэхүү журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мөрдлөг болгон ажиллаж байна. ТӨБЗГ-ын цахим хуудас http://pcsp.gov.mn/file/1111–д байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангасан. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 1.8.8. “Аймаг, нийслэл дэх орон сууц хувьчлах товчооны ажиллах журам”, “Орон сууц эзэмших эрхийн бичиг олгох журам”-ын төслийг боловсруулах</p>	<ul style="list-style-type: none"> - Журмын төслийг боловсруулах; - Төслийг байгууллагын цахим хуудас www.pcsp.gov.mn –д байршуулж, олон нийтийн зүгээс танилцаж, санал өгөх боломж бүрдүүлэх; - Журмын төсөлд аймаг, нийслэлийн Засаг даргаас санал авах; - Журмын төслөөр хэлэлцүүлэг зохион 	<p>Орон сууц хувьчлах ажлыг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулах эрх зүйн орчин тодорхой болно.</p>	<p>БТУХ</p>	<p>Аймаг, нийслэл дэх төрийн өмчийн орон сууцыг Орон сууц хувьчлах тухай хуулийн дагуу хувьчлах ажлыг зохион байгуулахтай холбоотойгоор “Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам”-ын төслийг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргаас санал авч, холбогдох байгууллагуудтай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулан саналыг нэгтгэн боловсруулж, төсөлд тусгасан. “Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам”-ын төслийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн 67 дугаар тогтоолоор батлан мөрдөж байгаа бөгөөд ТӨБЗГ-ын 2017 оны 91 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан. Журмыг байгууллагын цахим хуудас http://pcsp.gov.mn/file/1090 –д</p>

	<ul style="list-style-type: none"> байгуулах; - Саналыг нэгтгэн боловсруулж, төсөлд тусгах; - Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах; - III сард. 			<p>байршуулж, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.</p> <p>Орон сууц хувьчлах ажлын хүрээнд нийтийн орон сууцанд дахь эзэмшлийн хэмжээг газар дээр нь очиж хэмжилт хийн тогтоож, 2017 онд нийт 81 иргэнд “Орон сууц эзэмших эрхийн бичиг”-ийг олгосон.</p> <p>(“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 1.9.9.</p> <p>Төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ)-ын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчит үйлдвэрийн газруудын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, дүрмийн төслийг боловсруулах; - Хууль, эрх зүйд нийцүүлэх; - Холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас санал авч тусгах; - Газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг бэлтгэх; - Газрын хуралдааны шийдвэрээр батлуулсан байх; - I сард. 	Төрийн өмчит үйлдвэрийн газрууд үр ашигтай ажиллах боломжтой болсон байна.	БТУХ	<p>“Буянт-Ухаа спортын ордон” ТӨҮГ, “Цагаан шонхор” ТӨҮГ, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ, “ТОСК” ТӨҮГ, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨҮГ, “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ, “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК, “Ховд дулааны станц” ТӨХК, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК, “Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨҮГ, “Хөвсгөл дулааны станц” ХК зэрэг төрийн өмчит хуулийн этгээдийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, дүрмийн төслийг хууль, эрх зүйд нийцүүлэн боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас санал авч, ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн баталсан. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 1.10.10.</p> <p>Шинээр томилогдсон гүйцэтгэх захирал, захирлуудтай контракт байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Гүйцэтгэх захирал, захирлуудтай байгуулах контрактын төслийг хууль эрх зүйд нийцүүлэн боловсруулах; - Контракт байгуулах; - I-II сард. 	Хууль журамд нийцсэн контракт байгуулсан байна.	БТУХ	<p>ТӨБЗГ-ын 2017 оны “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам батлах тухай” 90 дүгээр тогтоолын хавсралтаар гүйцэтгэх захирал, захирлуудтай байгуулах контрактын үлгэрчилсэн загварыг батлуулж, шинээр томилогдсон болон үргэлжлүүлэн ажиллаж байгаа нийт 71 хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захиралтай хууль, эрх зүйд нийцүүлэн Контрактыг шинэчлэн байгуулсан байна. (“Бүрэн хэрэгжсэн” -100%)</p>
<p>Арга хэмжээ 1.11.11.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн судалгааг шинэчлэн гаргаж, дүгнэлт хийх</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага болон ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлсний судалгаа хийх; - Гүйцэтгэх захирал, 	Төрийн өмчийн бодлого, удирдлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, авах арга хэмжээ тодорхой болно.	БТУХ	<p>ТӨБЗГ-ын 2017 оны А-1/993, А-1/1398 дугаар албан бичгээр компани, үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн талаарх мэдээлэл ирүүлэх хүсэлтийг хүргүүлж, ирүүлсэн мэдээллийг нэгтгэн боловсруулж, 2016 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, 2017 оны төлөвлөгөөг нэгтгэн гаргасан.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн сүүлийн 5 жилийн үзүүлэлтийг нэгтгэн товхимол болгож, мэдээлэл, лавлагаа, сурталчилгаанд ашиглаж байна.</p>

	<p>захирлуудын судалгааг шинэчлэх;</p> <ul style="list-style-type: none"> - ТУЗ-ийн бүрэлдэхүүний судалгааг шинэчлэн гаргах; - Хийсэн судалгаанд дүгнэлт хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох; - Тухай бүр. 			<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, дэд захирал, ерөнхий нягтлан бодогч нарын судалгаа, ТУЗ-ийн дэргэдэх дэд хорооны судалгаа, ТУЗ-ийн гишүүдийн судалгаа, захирлын болон ТУЗ-ийн гишүүдийн цалингийн судалгаа, 2017-2020 оны зорилтын санал зэргийг нэгтгэн гаргасан.</p> <p>Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогчийн мэргэшсэн эсэх талаарх судалгааг авч нэгтгэв. Судалгааны дүнгээр ерөнхий нягтлан бодогч нь мэргэшээгүй төрийн өмчит 8 хуулийн этгээд (“Дулааны цахилгаан станц-2” ТӨХК, “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК, “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК, “Ховд дулааны станц” ТӨХК, “Налайхын дулааны станц” ТӨХК, “Хөвсгөл дулааны станц” ТӨХК, “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ, “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ)-д ТӨБЗГ-ын А-1/2812-А-1/2819 дүгээр албан бичгийг тус тус хүргүүлж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл өгөв. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 1.12.12.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох ногдол ашгийг төвлөрүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Ногдол ашгийг төвлөрүүлэх тооцоо судалгааг хийж, ашиг, алдагдлыг тодорхойлох; - Газрын хуралдаанд танилцуулж, шийдвэр гаргуулах; - Төрд ногдох ногдол ашгийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангах; - Жилдээ. 	<p>2017 оны жилийн эцэст ашигтай ажилласан компаниудын цэвэр ашгаас 25,0 тэрбум төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлнэ. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн холбогдох заалт хэрэгжинэ. Алдагдалтай ажиллаж байгаа аж ахуйн нэгжийн тоог 20-30 хувиар бууруулна.</p>	БТУХ	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 41 хуулийн этгээд 2016 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан тэнцлээр 92.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд 2017 онд ногдол ашгийг цэвэр ашгийн 15-30 хувиар тооцож, нийт 13.5 тэрбум төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлэх асуудлыг газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2017 оны 117 дугаар тогтоолоор баталсан. Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж, 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 39 хуулийн этгээд 9.77 тэрбум төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлээд байна. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 1.13.13.</p> <p>Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон</p>	<ul style="list-style-type: none"> - Гэрээний биелэлтийг дүгнэх; - Гэрээг сунгах эсэх асуудлыг Газрын 	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой	БТУХ	<p>Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захиралтай байгуулсан 2016 оны гэрээг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын</p>

<p>төрийн оролцоотой этгээдийн гүйцэтгэх байгуулсан 2016 оны гэрээг дүгнэх</p>	<p>өмчийн хуулийн захирал, захиралтай</p>	<p>хуралдаанд танилцуулах; - Шийдвэр гаргуулах; - I улиралд.</p>	<p>хуулийн этгээдийн удирдлагын үүрэг, хариуцлагын үр дүн дээшилнэ.</p>	<p>дагуу дүгнэж, ажлын хэсгээр хэлэлцүүлсний үндсэн дээр 72 хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захиралтай байгуулсан 2016 оны гэрээг дүгнэж, ТӨБЗГ-ын хуралдааны шийдвэрээр баталгаажуулсан. Гэрээг дүгнэсэн дүнгийн талаарх ТӨБЗГ-ын тогтоолуудыг хуулийн этгээд бүрээр цахим хуудсанд байршуулан, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллав. (“Бүрэн хэрэгжсэн” – 100 %)</p>
<p>Арга хэмжээ 1.14.14. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын 2011-2016 оны жилийн эцсийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн нэгдсэн санг бий болгох</p>	<p>- 2011-2016 оны санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг нэгтгэх программ хангамжийн шийдлийг боловсруулах, эхний хагас жилд; - 2016 оны дүнг нэгтгэн боловсруулж, дүгнэлт гаргах; - Танилцуулга бэлтгэж, товхимол, гарын авлага гаргах; - Хэрэглэгч, олон нийтийн хүртээл болгох; - Цахим хуудсанд байршуулан мэдээлэх; - II улиралд.</p>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын санхүү, эдийн засгийн үзүүлэлт ил тод мэдээлэгдсэн байна.</p>	<p>БТУХ</p>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үзүүлэлт, судалгаа, үйл ажиллагааны танилцуулга, баримт мэдээллийг тусгасан эмхэтгэл гаргаж, төсвийн орлогыг тооцож төвлөрүүлэх, өмч хувьчлалын хөтөлбөрийг төлөвлөн хэрэгжүүлэх, салбарын бодлого боловсруулахад чиглэсэн албаны хэрэгцээнд зориулан 2017 оны А-1/764 дугаар албан бичгээр холбогдох яам, агентлаг, орон нутгийн төр, захиргааны байгууллагын удирдлагад хүргүүлсэн. Эрчим хүчний үнэ тарифын өнөөгийн байдал, цаашид үнэ тарифт өөрчлөлт оруулах нь оновчтой эсэх талаар холбогдох компаниудаас санал авч, нэгтгэсэн. ТӨБЗГ-аас Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороотой хамтран ажиллах талаар ажил хэргийн уулзалтыг 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсан бөгөөд харилцан санамж бичиг байгуулав. (“Бүрэн хэрэгжсэн” – 100 %)</p>
<p>Арга хэмжээ 1.15.15. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын 2016 оны жилийн эцсийн тайлан тэнцлийн дүнд тусгагдсан бараа, материалын үлдэгдэл, өр төлбөр, авлагыг бууруулах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх</p>	<p>- Бараа материалын үлдэгдэл, өр төлбөр, авлагын талаар дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах; - Чиглэл, авах арга хэмжээг боловсруулах; - Холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж, батлуулах; - Холбогдох компаниудад хүргүүлж, хэрэгжүүлэх</p>	<p>Бараа, материалын үлдэгдэл, өр төлбөр, авлагыг тус бүр 10-30 хувиар бууруулсан байна.</p>	<p>БТУХ</p>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйлдвэрлэл, санхүүгийн үр ашгийг өмнөх оноос дээшлүүлэх, алдагдалгүй ажиллах, авлага, өглөгийг бууруулах, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардлыг хямдруулах зарчмыг баримтлан 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хянаж баталсан. Үүний үр дүнд гарсан зарим үзүүлэлтийг дурдвал, 2017 оны эхний хагас жилийн тайлан тэнцлийн дүнгийн зарим үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төрийн өмчит хуулийн этгээдийн нийт хөрөнгө 8 их наяд 903 тэрбум төгрөг болсон. Нийт орлого 3 их наяд 431 тэрбум төгрөгт хүрч 1 их наяд 239 тэрбум төгрөгөөр буюу 56.6 хувиар өссөн. Төрийн өмчит компаниудын нийт өр төлбөр 3.5 их наяд төгрөг, үүнээс богино хугацаат өр төлбөр 1 их наяд 369 тэрбум төгрөг, урт хугацаат өр төлбөр 2 их наяд 167 тэрбум төгрөг болсон. Үүнд Хөгжлийн банк, Төрийн банкны өр төлбөрийн дүн ороогүй. Төрийн өмчит компаниудын өр төлбөрийн нийт дүн 2016 оны эхний хагас жилийн байдлаар 10.8 их наяд төгрөг байсан</p>

	<p>арга хэмжээ авах;</p> <ul style="list-style-type: none"> - Хэрэгжилтийг тооцон дүгнэх; - Жилдээ. 			<p>бол 2017 оны эхний хагас жилийн дүнгээр төрийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр 3.5 их наяд төгрөг, Хөгжлийн банк, Төрийн банкны өр төлбөр 5.2 их наяд төгрөг, нийт өр төлбөр 8.7 их наяд төгрөг болсон байна. Төрийн өмчит компаниудын нийт өр төлбөр 2017 оны эхний хагас жилийн дүнгээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.1 их наяд төгрөгөөр буюу 24.8 хувиар буурсан байна. Жилийн эцсийн тайлан баланс одоогоор гараагүй байна. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 1.16.16. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих</p>	<ul style="list-style-type: none"> - Аудитын үр дүнд залруулга хийсэн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын санхүүгийн тайлан, тэнцлийг нэгтгэж, анализ хийх; - Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт, мониторинг хийх; - Хяналт, мониторингийн дүнг ажлын үр дүнд харгалзах; - Жилдээ. 	<p>Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, тэнцэл гарч, олон улсын стандартад нийцсэн байна. Хяналтын тогтолцоонд дэвшил гарсан байна.</p>	<p>БТУХ</p>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад хийсэн аудитын зөвлөмжийн биелэлтийг гаруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын санхүүгийн тайлан, тэнцлийг нэгтгэн, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн стандартыг хангаж байгаа байдалд хяналт тавин ажиллав.</p> <p>Үндэсний аудитын газрын Ерөнхий аудиторын 2017 оны А/191 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг мөрдлөгө болгон ажиллах чиглэлийг 2017 оны А-1/3319, А-1/3320 дугаар албан бичгээр хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлсэн.</p> <p>(“Хэрэгжих шатанд” - 70%)</p>
<p>Арга хэмжээ 1.17.17. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд өгсөн удирдамжийн биелэлтийг тооцон дүгнэх</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлөөс удирдамжийн биелэлтийг хүлээн авч, нэгтгэн дүгнэх; - Удирдамжийн биелэлтэд нэгдсэн дүгнэлт гарган, танилцуулга бэлтгэх; - Газрын хуралдаанд танилцуулах; - YI, XII сард. 	<p>Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам, газрын хуралдааны шийдвэрийн биелэлт хангагдсан байна.</p>	<p>БТУХ</p>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд ТӨБЗГ-аас удирдамж өгч, удирдамжийн биелэлтийг 3-5 хоногт ирүүлэх үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад өгч, биелэлтэд нь хяналт тавьж ажилласан.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх захирлын 2017 оны контрактын гэрээг дүгнэхдээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан, удирдамжийн биелэлт, танилцуулгыг авч нэгтгэн ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулахаар бэлтгэж байна.</p> <p>(“Хэрэгжих шатанд” - 70%)</p>
<p>Арга хэмжээ 1.18.18. УИХ, Засгийн газраас өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэхээр гаргасан “Албан даалгавар”-ын хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, үр дүнг тооцох</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай газар дээр нь 	<p>УИХ-ын 2016 оны 69 дүгээр тогтоол, Засгийн газрын 2016 оны 41 дүгээр тэмдэглэлээр</p>	<p>БТУХ</p>	<p>Улсын Их Хурлын “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2016 оны 69 дүгээр тогтоол, Засгийн газрын хуралдааны “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 2016 оны 41 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу төрийн өмчит компаниудын үйлдвэрлэл, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх, авлага, өглөгийг бууруулах зарчмыг баримтлан ажиллаж, 2017 оны</p>

	<p>танилцах;</p> <ul style="list-style-type: none"> - Албан даалгаврын биелэлтийг хүлээн авч, нэгтгэн дүгнэх; - Цаашид авах арга хэмжээг тодорхойлон шийдвэрлэж ажиллах; - I улиралд. 	<p>өгсөн үүрэг чиглэлийн хэрэгжилтэд ахиц гарсан байна.</p>		<p>эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хянаж баталсны дүнд эхний хагас жилийн байдлаар үр дүн гарсан. Энэ талаар мэдээлэл боловсруулан УИХ, Засгийн газар, ЗГХЭГ болон холбогдох яамдыг мэдээллээр ханган ажиллав. Үүнд:</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь 2016 оны эхний хагас жилд 15.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол 2017 оны эхний хагас жилд 459.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ашиг 30 дахин өсч, компаниудын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавх сайжирсан. 2017 оны эхний хагас жилийн тайлан тэнцлийн дүнгийн зарим үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төрийн өмчит хуулийн этгээдийн нийт хөрөнгө 8 их наяд 903 тэрбум төгрөг болсон, нийт орлого 3 их наяд 431 тэрбум төгрөгт хүрч, 1 их наяд 239 тэрбум төгрөгөөр буюу 56.6 хувиар өссөн, төрийн өмчит компанийн өр төлбөрийн нийт дүн 8.7 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.1 их наяд төгрөгөөр буюу 24.8 хувиар буурсан.</p> <p>2016 онд зохион байгуулагдсан төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын дүнгээс үзэхэд Төрийн өмчит хуулийн этгээдэд 2012-2015 онд нийт 170 жип ангиллын автомашиныг 18.8 тэрбум төгрөгөөр, жилд дунджаар 42 ширхэг жип ангиллын автомашиныг 4.7 тэрбум төгрөгөөр тус тус худалдан авч байсан бол 2016-2017 онд нэг жилд 10 жип ангиллын автомашиныг 1.4 тэрбум төгрөгөөр шинээр худалдан авсан нь автомашин худалдан авах зардлыг өмнөх гүйцэтгэлтэй харьцуулахад 3.3 тэрбум төгрөг буюу 70.2 хувиар бууруулсан байна.</p> <p>Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогыг нэмэгдүүлэх болон төрийн өмчийг хувьчлах ажлыг амжилттай зохион байгуулсны үр дүнд 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар өмч хувьчлалын орлого 16.2 тэрбум төгрөг, ногдол ашгийн орлого 9.7 тэрбум төгрөг, түрээсийн болон бусад орлого 0.9 тэрбум төгрөг, нийт 26.8 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээд байна. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 1.19.19. Орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газарт шалгалт хийж, нэгдсэн дүнг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Орон нутагт ажиллах баг бүрэлдэхүүнийг томилж, хуваарь гаргах; - Удирдамж боловсруулан батлуулах; - Удирдамж, хуваарийн дагуу орон нутагт 	<p>Орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газрын үйл ажиллагааг сайжруулах талаар авах арга хэмжээ тодорхой</p>	<p>БТУХ, Орон нутагт ажиллах багийн гишүүд</p>	<p>Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хорооны 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 20 дугаар тэмдэглэлээр “Орон нутгийн өмчит компаниудад шалгалт хийх, дүнг танилцуулах” үүргийг хэрэгжүүлэх зорилгоор ТӨБЗГ-ын даргын 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар Ажлын хэсэг байгуулан, удирдамж баталсны дагуу 7 чиглэлд 14 ажлын хэсэг ажилласан. 21 аймгийн орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын үйл ажиллагаатай танилцан, шалгалт хийж, ерөнхий мэдээлэл болон эдийн засгийн үндсэн үзүүлэлтээр</p>

	<ul style="list-style-type: none"> ажиллах; - Шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт хийж, танилцуулга, авах арга хэмжээг боловсруулах; - Газрын хуралдаан болон УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж, авах арга хэмжээний шийдвэр гаргуулах; - III сард. 	болно.		судалгаа хийж, нэгтгэн ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулсан. УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороонд 2017 оны А-1/973 дугаар албан бичгээр шалгалтын нэгдсэн дүнг хүргүүлсэн. ("Бүрэн хэрэгжсэн" -100%)
<p>Арга хэмжээ 1.20.20. "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн 2016 оны үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн байдалд шалгалт хийж, дүгнэлт гаргах</p>	<ul style="list-style-type: none"> - Ажлын хэсэг байгуулж, удирдамж батлах; - Компанийн үйл ажиллагаан шалгалт хийх; - Тайланг нэгтгэн боловсруулж, дүгнэлт гаргаж, танилцуулга бэлтгэх; - Газрын хуралдаанаар хэлэлцүүлэх; - УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд танилцуулж, цаашид авах арга хэмжээг батлуулах; - IY сард. 	"Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн үйл ажиллагааны үр ашиг, удирдлага, менежментийн талаар цогц дүгнэлт гарч, цаашид авах арга хэмжээ тодорхой болно.	БТУХ, Ажлын хэсэг	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/17 дугаар тушаалаар "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн 2016 оны үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн байдалд шалгалт хийх Ажлын хэсгийг байгуулж, удирдамжийг баталсан. Батлагдсан удирдамжийн дагуу "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн 2016 оны үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд шалгалт хийх үүрэг бүхий Ажлын хэсэг 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 22-ны өдрүүдэд газар дээр нь ажилласан.</p> <p>Ажлын хэсгийн даргын баталсан ажил үүргийн хуваарийн дагуу холбогдох хууль тогтоомж, шалгалтын удирдамжийн хүрээнд хяналт шалгалтын ажлыг хийж, судалсны дагуу тайлан дүгнэлтийг гаргасан.</p> <p>Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 181/Ш32017/05415 дугаар захирамжаар "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулахгүй байх, компанитай холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байхыг даалгасан учир Ажлын хэсгийн тайлангийн зөвхөн дүгнэлт хэсгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, захирал Х.Бадамсүрэнд зарим зөрчил дутагдлыг арилгах талаар гишүүд саналаа хэлж үүрэг болгосон.</p> <p>("Бүрэн хэрэгжсэн" -100%)</p>
<p>Арга хэмжээ 1.21.21. Төрийн өмчийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах бэлтгэл хангах</p>	<ul style="list-style-type: none"> - Ажлын хэсэг байгуулах; - Бодлогын баримт бичиг боловсруулахад шаардлагатай холбогдох судалгаа, тооцоолол хийх; 	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль	БТУХ	<p>Төрийн өмчийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах бэлтгэл хангах ажлын хүрээнд урьдчилсан байдлаар бодлогын баримт бичгийг боловсруулж, удирдлагын түвшинд танилцуулсан.</p> <p>Бодлогын баримт бичиг боловсруулахад шаардлагатай судалгаа, тооцоолол хийх ажлын хүрээнд холбогдох яамдаас төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, нэгтгэх, татан буулгах, үл хувьчлах</p>

	<ul style="list-style-type: none"> - Сонирхогч болон хэрэглэгч бүлгүүдтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах; - Ү сард. 	болон Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын дагуу боловсруулж эхэлсэн байна.		хөрөнгийн жагсаалтын талаар санал авч нэгтгэн ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулсан. Цаашид ажлын хэсэг байгуулан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль болон Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын дагуу боловсруулах ажлыг эхлүүлэн сонирхогч болон хэрэглэгч бүлгүүдтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөж байна. (“Хэрэгжилт хангалтгүй” – 30%)
<p>Арга хэмжээ 1.22.22.</p> <p>Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын удирдах ажилтны семинар зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Сургалтын сэдэв, хөтөлбөрийг тогтох; - Удирдлагын Академи, Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулах; - ҮI сард. 	Удирдах ажилтны чадавхи сайжирна. Нэгдсэн удирдлагаар хангагдана.	БТУХ, ЗХЗХ	<p>“Компанийн засаглалын үндэсний зөвлөл” ТББ-тай хамтран төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарт 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр компанийн засаглалын чиглэлээр сургалт явуулж, нийт 220 гаруй компанийн эрх бүхий албан хаагчид хамрагдсан.</p> <p>Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд шинээр томилогдсонтой холбогдуулан “Компанийн засаглалын үндэсний зөвлөл” ТББ-тай хамтран “ТУЗ-д хараат бус гишүүдийн үүрэг, компанийн засаглал” сэдвээр 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдөр сургалт зохион байгуулж, 92 хараат бус гишүүнийг хамруулав.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх удирдлага болон холбогдох албан тушаалтныг оролцуулсан.</p> <p>(“Бүрэн хэрэгжсэн” -100%)</p>
<p>ХӨТӨЛБӨР II</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн бодлого, удирдлагын оновчтой хэлбэрийг хэрэгжүүлж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулан үр ашгийг дээшлүүлэх, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд:</p>				
<p>Арга хэмжээ 2.1.23.</p> <p>Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө</p>	<ul style="list-style-type: none"> - Боловсруулалтыг бүрэн хийж, төслийн танилцуулга бэлтгэх; - Газрын хуралдаанаар төслийг хэлэлцүүлэн батлуулах, I сард; - Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлэх; 	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот	БТУХ	Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТУЗ болон Ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргаж, 76 хуулийн этгээдийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг нэгтгэн ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн баталсан. 30 хуулийн этгээдийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тодотголыг ТӨБЗГ-ын 8-10 дугаар сарын 5 удаагийн хуралдаанаар шийдвэрлүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан.

<p>оруулалтын төлөвлөгөөг батлуулах</p>	<p>- I улиралд.</p>	<p>түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт тавих боломжтой болно.</p>		<p>Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянах Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, 50 гаруй хуулийн этгээдийн 2018 оны төлөвлөгөөг Ажлын хэсгээр хэлэлцүүлж, ТӨБЗГ-ын хуралдаанд оруулахаар бэлтгээд байна. “Монгол ус” ТӨҮГ, “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ, “Геологийн төв лаборатори” ТӨҮГ, “Геологийн судалгааны төв” ТӨҮГ, “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” ТӨҮГ, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК зэрэг төрийн өмчит хуулийн этгээдийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулаад байна. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 2.2.24. “Барилгын хөгжлийн төв”, “Автотээврийн үндэсний төв”, “Төрийн орон сууцны корпораци” зэрэг төрийн өмчит үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах арга хэмжээ авах</p>	<ul style="list-style-type: none"> - Өөрчлөн байгуулах үндэслэл, судалгааг гаргах; - Компанийн хэлбэрт шилжүүлэх асуудлыг боловсруулах; - Тогтоолын төсөл, танилцуулга бэлтгэх; - Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх; - I сард. 	<p>Алдагалтай ажиллаж байгаа ТӨҮГ-уудын менежмент сайжирч, ашигтай ажиллах боломж бүрдэнэ. Удирдлагын шийдвэр гаргалтад тавих хяналт сайжирна.</p>	<p>БТУХ</p>	<p>“Барилгын хөгжлийн төв”, “Автотээврийн үндэсний төв”, “Төрийн орон сууцны корпораци” зэрэг төрийн өмчит үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах үндэслэл, судалгааг гаргаж, холбогдох салбарын яамнаас санал авч нэгтгэн компанийн хэлбэрт шилжүүлэх асуудлыг боловсруулж, тогтоолын төсөл, танилцуулга бэлтгэн ТӨБЗГ-ын хуралдаанаар 2 удаа зохих нэмэлт, өөрчлөлт оруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн. Ажлын хариуцлага, санхүүгийн хяналт хангалтгүй, удирдлага менежментийг сайжруулах шаардлагатай байгаа, өр төлбөр үүсэх, хөрөнгө зарцуулах зэрэгт хяналт сул, зөвхөн төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын эрх, үүргийн хүрээнд ажлыг гүйцэтгэдэг зэргийг харгалзан компанийн хэлбэрт оруулснаар хамтын шийдвэрээр үйл ажиллагаа явуулж, зардлыг бууруулах, өр төлбөр үүсэх нөхцлийг хяналттай болгох, үр ашгийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ гэж үзсэн. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 2.3.25. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалын, эрсдэлийн үнэлгээний, дотоод аудитын тайлангууд, төлөөлөн удирдах зөвлөл болон хороодын тайланг үнэлж, дүгнэн хариуцлагын тогтолцоог</p>	<ul style="list-style-type: none"> - Тайлангийн стандарт гаргах, нэвтрүүлэх, хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд чиглэл, удирдамж өгөх; - Тайланг үнэлж, дүгнэн, цаашид авах арга хэмжээг 	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх боломж бүрдэж, компанийн засаглал</p>	<p>БТУХ, “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ, “Олон Улсын санхүүгийн корпораци” ТББ</p>	<p>Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захиралтай байгуулсан 2017 оны контрактыг 2018 оны эхний улиралд дүгнэхдээ компанийн засаглалын үнэлгээ, дотоод аудитын тайлангууд, төлөөлөн удирдах зөвлөл болон хороодын тайланг нэгтгэн авч үнэлэлт дүгнэлт өгнө. Тайлангийн хугацаанд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд энэ талаар чиглэл, удирдамж өгч ажилласан. “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ, “Олон Улсын санхүүгийн корпораци” ТББ-тай хамтран Олон Улсын тайлагналын стандарт нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, “Шилдэг тайлан шалгаруулах I уралдаан”-д “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК амжилттай</p>

тодорхой болгох	<p>тодорхойлж, хэрэгжүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> - “Шилдэг тайлан шалгаруулах II уралдаан”-ыг зохион байгуулах; - Жилдээ. 	сайжирна.		оролцож шагнал хүртсэн. “Шилдэг тайлан шалгаруулах II уралдаан”-ыг зарлан зохион байгуулж байна. Уралдааныг хуулийн этгээдийн тайлан баталгаажсны дараа буюу 2018 оны эхний улиралд дээрх байгууллагуудтай хамтран дүгнэнэ. (“Хэрэгжих шатанд” - 70%)
<p>Арга хэмжээ 2.4.26.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, үйл ажиллагааны мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтийн ил тод байдлыг хангах арга хэмжээ авч, хяналт тавих</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг чиглэл, зөвлөмжөөр хангах; - Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, хяналт тавих; - Дотоод аудитын дүнг нэгтгэж, дүнгийн мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - Дотоод аудит, хяналтын мэдээллийг цахим хуудсанд байршуулж, олон нийтэд ил тод мэдээлэх; - Жилдээ. 	Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	БТУХ, ЗХЗХ	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 96 хуулийн этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар ТӨБЗГ-аас 2017 оны А-1/391 дүгээр албан бичгээр чиглэл өгсөн. Тайлант хугацаанд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 97 хуулийн этгээдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, 2016 оны байдлаар шилэн дансны цахим бүртгэлд бүртгүүлээгүй, мэдээ, тайлангаа Шилэн дансны цахим системд оруулж, ил тод мэдээлээгүй 11 хуулийн этгээдэд “Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх тухай” зөвлөмж, чиглэлийг ТӨБЗГ-ын 2017 оны А-1/509, А-1/510 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 100 хуулийн этгээдэд 2017 оны эхний хагас жилийн байдлаар байдлаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдалд аудит хийж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай 2017 оны А-1/2250 дугаар албан бичгийг хүргүүлсэн.</p> <p>Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулсан 2016 оны гэрээг дүгнэхэд мэдээллийн ил тод байдлыг хангаж байгаа байдал, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн байдлыг харгалзан дүгнэсэн, 2017 оны контрактыг 2018 оны эхний улиралд дүгнэнэ.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг эмхэтгэн товхимол хэвлүүлж, албаны хэрэгцээнд тарааж, мэдээллийн ил тод байдлыг ханган сурталчилсан. (“Хэрэгжих шатанд” - 70%)</p>
<p>Арга хэмжээ 2.5.27.</p> <p>“Компанийн засаглалын үндэсний зөвлөл” ТББ-тай байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх тусгай төлөвлөгөөтэй ажиллах</p>	<ul style="list-style-type: none"> - Төлөвлөгөөний төслийг боловсруулж, холбогдох байгууллага, албан хаагчдаас санал авч тусгах; - Талууд зөвшилцөх; - Төлөвлөгөөг 	Компанийн засаглалын чиглэлээр ТББ-тай хамтран ажиллаж, олон улсын стандартыг хэрэгжүүлнэ.	БТУХ	<p>“Компанийн засаглалын үндэсний зөвлөл” ТББ-тай байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажилласан. Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд “Компанийн засаглалын үндэсний зөвлөл”-ийн дэргэдэх “Сайн засаглал” сэтгүүлийн тусгай дугаарыг “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага - 2017” нээлттэй өдөрлөгийн арга хэмжээнд зориулан гаргасан.</p> <p>“Компанийн засаглалын үндэсний зөвлөл” ТББ-тай хамтран төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах</p>

	<p>батлуулах, I сард;</p> <ul style="list-style-type: none"> - Төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх; - Хэрэгжилтийг хангаж ажиллах, Жилдээ. 			<p>зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд зэрэг компанийн эрх бүхий 312 албан тушаалтныг хамруулж, ТУЗ-ийн гишүүдийн эрх, үүргийг хэрэгжүүлэх, компанийн засаглалтай холбоотой сэдвээр нийт 2 удаа сургалт зохион байгуулав. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 2.6.28. “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага” өдөрлөг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Ажлын хэсэг байгуулж, удирдамж боловсруулан батлуулах; - Өдөрлөгийн бэлтгэл ажлын төлөвлөгөө, өдөрлөгийн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах; - Шаардагдах хөрөнгийн тооцоо хийж батлуулах; - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, оролцуулах; - Өдөрлөгийн тайлан, мэдээллийг Ерөнхий сайдын ажлын албанд хүргүүлэх; - Өдөрлөгийг IY/07-08-ны өдрүүдэд “Тэнгэр плаза” төвд зохион байгуулах; - “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага” форумыг IY/14-ний өдрүүдэд Төрийн ордонд зохион байгуулах. 	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа олон нийтэд ил тод болно. Дотоодын үйлдвэрлэгчидтэй хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ. Төр, хувийн хэвшлийн түншлэл сайжирна.</p>	<p>БТУХ</p>	<p>2017 оны 04 дүгээр сарын 07, 08-ны өдрүүдэд “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага - 2017” сэдэвт нээлттэй өдөрлөгийг төрийн өмчийн оролцоотой компаниудын үйлчилгээг нэг цэгээс иргэдэд хүргэх, үйл ажиллагааг нь олон нийтэд сурталчлах, импортыг орлох бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үндэсний үйлдвэрүүдийг дэмжих, хамтарч ажиллах нөхцөл бүрдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг идэвхжүүлэх замаар эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг даван туулахад чиглэсэн ажил хэрэгч хамтын ажиллагааг өрнүүлэх зорилгоор зохион байгуулсан.</p> <p>Өдөрлөгийн үеэр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар төрөөс баримталж буй бодлого, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаар оролцогчдод мэдээлэл хүргэх, хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах зэрэг олон талт ажлууд зохион байгуулагдсан.</p> <p>“Төрийн өмчийн менежмент ба Нийгмийн хариуцлага - 2017” өдөрлөгт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 80 гаруй компани, аж ахуй нэгж, 150 гаруй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид оролцсон. Энэхүү арга хэмжээний нээлтэд Монгол Улсын Ерөнхий сайд асан Ж.Эрдэнэбат оролцон үг хэлж, удирдлагуудад зарим чиглэл, даалгавар өгсөн. Төрийн өмчийн компаниуд үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй, ил тод байлгах ажлын эхлэлийг уг арга хэмжээгээр тавьж, цаашид тухай бүр тайлагнахыг үүрэг болгосон. Нээлттэй өдөрлөгийн тайланг нэгтгэн боловсруулж, Ерөнхий сайдын Ажлын албанд хүргүүлсэн. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 2.7.29. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох</p>	<ul style="list-style-type: none"> - Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг боловсруулах; - Өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр 	<p>Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ-ийн бүтэц,</p>	<p>БТУХ</p>	<p>Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 81 дүгээр зүйлийн 81.5.1, 81.5.2, 81.5.3 дахь заалтыг үндэслэн төрийн өмчит 32 компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах зарыг Өдрийн сонины 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 063 дугаарт нийтлүүлж, олон нийтэд мэдээлсэн. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороодын ирүүлсэн хараат бус гишүүдийг сонгон</p>

	<p>ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах зарыг олон нийтэд түгээж, тавигдах шаардлагыг сурталчлах;</p> <ul style="list-style-type: none"> - Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, тухайн ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшүүлсэн хараат бус гишүүдийг томилуулах арга хэмжээ авах; - I-III сард. 	<p>бүрэлдэхүүн бүрэн шинэчлэгдсэн байна.</p>		<p>шалгаруулах дүгнэлтийг нэгтгэн холбогдох хууль, журамд заасан шаардлага нөхцөлийг хангаж байгаа эсэхийг хянан үзэж, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг ТӨБЗГ-ын даргын 2017 оны А/53 дугаар тушаалаар томилон ажиллуулав. Ажлын хэсгийн дүгнэлтийг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, 52 хараат бус гишүүнийг чөлөөлөх, 39 хараат бус гишүүнийг үргэлжлүүлэн томилох, 53 хараат бус гишүүнийг 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн шинээр томилох тухай ТӨБЗГ-ын 2017 оны 195, 196 дугаар тогтоол гаргасан. Нийт 46 Төлөөлөн удирдах зөвлөлд 132 хараат бус гишүүн ажиллаж байна. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 2.8.30. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чадавхижуулахад чиглэсэн сургалт зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Сургалтын хөтөлбөр, график төлөвлөгөө боловсруулан батлуулах; - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хамруулах; - II, III улиралд. 	<p>Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэхээр томилогдсон албан хаагч тухайн салбарын онцлогийн талаар ойлголт, мэдлэгтэй болж, чадавхи нь дээшилнэ.</p>	<p>БТУХ</p>	<p>Улсын Их Хурлын 2016 оны 69 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулах зарчмыг баримтлан ажилласны үр дүнд нийт Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болох яам, агентлаг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас томилогдсон төлөөлөл 65.7 хувийг эзэлж байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн 46 Төлөөлөн удирдах зөвлөлд 403 гишүүн ажиллаж байгаагаас Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй 271 гишүүн, хараат бус болон хувийн төлөөлөл хэрэгжүүлж буй 132 гишүүн байна. Дээр дурьдсан 403 гишүүн бүгд компанийн засаглалын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан гэрчилгээтэй ба “Компанийн засаглалын үндэсний зөвлөл” ТББ-тай хамтран 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулсан ТУЗ-ийн гишүүдийг чадавхижуулах сургалтад 220 хүнийг хамруулсан. Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд шинээр томилогдсонтой холбогдуулан “Компанийн засаглалын үндэсний зөвлөл” ТББ-тай хамтран “Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн үүрэг роль, компанийн засаглал” сэдвээр 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдөр чадавхижуулах сургалт зохион байгуулж, хараат бус 92 гишүүнийг хамруулав. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 2.9.31. Орон нутаг дахь төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани,</p>	<ul style="list-style-type: none"> - Удирдамж, орон нутагт ажиллах бүрэлдэхүүн, хуваарь боловсруулан батлуулах; - Зөвлөн туслах ажилд 	<p>Төрийн өмчийн нэгдмэл удирдлага, мэдээллээр хангагдана.</p>	<p>БТУХ</p>	<p>Орон нутаг дахь төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн үйл ажиллагаа, өвөлжилтийн бэлтгэл ажлын явцтай газар дээр нь танилцах, тулгамдсан асуудлыг судлах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж, хуваарийг ТӨБЗГ-ын даргын 2017 оны А/141 дүгээр тушаалаар баталсан. Энэ ажлын хүрээнд Налайх, Багануур дүүрэг, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон</p>

салбар ААН-үүдэд зөвлөн туслах чиглэлээр ажиллах	шаардлагатай материал, гарын авлага бэлтгэх; - Орон нутагт ажиллах; - VII-VIII сард.			аймаг дахь төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 11 компани, үйлдвэрийн газар, салбар ААН-ийн үйл ажиллагаа, өвөлжилтийн бэлтгэл ажлын явцтай газар дээр нь танилцаж, тодорхой санал, зөвлөмжийг өгсөн. Ажлын хэсэгт ТӨБЗГ-ын дарга, дэд дарга, хэлтсийн дарга болон холбогдох мэргэжилтнүүд оролцсон. Мөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 34 компанийн үйл ажиллагаа, өвөлжилтийн бэлтгэл ажлын явцтай газар дээр нь танилцах, тулгамдсан асуудлыг судлах чиглэлээр БТУХ-ийн даргын баталсан 9 чиглэл бүхий хуваарийн дагуу 9 компани, үйлдвэрийн газарт ажилласан. Баян-Өлгий, Ховд, Хэнтий, Сүхбаатар аймаг дахь ОНӨГ, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах, шалган зааварчлах ажлыг хийв. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)
Хоёр. “Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хамгаалалттай холбоотой бүртгэл, тооллого явуулах, төрийн өмчийн бүрэн бүтэн байдал, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт тавих” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:				
ХӨТӨЛБӨР III “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг боловсронгуй болгож, өмчийн улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэн баяжуулж, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хөдөлгөөнийг зохицуулах” хөтөлбөрийн хүрээнд:				
Арга хэмжээ 3.1.32. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаан, УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх	<ul style="list-style-type: none"> - Холбогдох байгууллагаас санал авч нэгтгэх, дүгнэлт гаргах; - Эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх; - УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх асуудлын танилцуулга, материалыг бэлтгэн боловсруулах; - Шийдвэрийн төсөл боловсруулах; - УИХ-ын чуулганаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах; - I-II улиралд. 	Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх ажлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлсэн байна.	Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Цаашид “ТӨБХХ” гэх)	Холбогдох байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг судлан, баримтын бүрдлийг хангах арга хэмжээ авч, УИХ-ын “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төсөл, танилцуулга, үзэл баримтлалыг Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулав. УИХ-ын тогтоолын төслийн талаар 21 аймаг, нийслэлийн өмчийн харилцааны газар, холбогдох яамны төлөөллийг оролцуулан видео хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэн 35 дугаар тэмдэглэлээр дэмжсэн. УИХ-д өргөн мэдүүлэх талаар ХЗДХ-ийн сайд, Сангийн сайдаас зөвшөөрөл авч, ЗГХЭГ-т хүргүүлсэн. УИХ-ын тогтоолын төсөлд нийт 26.7 тэрбум төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр багтаасан болно. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)

<p>Арга хэмжээ 3.2.33. Орон нутгаас төрийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг судлан, эзэмшигч этгээдийг тогтоон шийдвэрлүүлэх арга хэмжээ авах</p>	<ul style="list-style-type: none"> - Орон нутгаас төрийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг судлах, тухай бүр; - ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх; - Шийдвэрийг хэрэгжүүлж, хөрөнгө хүлээлцэх, санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулах, Тухай бүр; - Жилдээ, тухай бүр. 	<p>Орон нутгаас төрийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна.</p>	<p>ТӨБХХ</p>	<p>Орон нутгаас төрийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг тухай бүр хууль тогтоомжид заасны дагуу дараах байдлаар шийдвэрлэн ажиллав:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 123.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, Гадаадын иргэн, харьяатын газарт эзэмшүүлж, бүртгэлд тусгах асуудлыг ТӨБЗГ-ын 2017 оны 262 дугаар тогтоолоор шийдвэрлэж, холбогдох байгууллагад албан бичгээр хүргүүлэн хэрэгжүүлсэн. 2. Дорнод аймгийн Хэрлэн сумын ЗДТГ-ын балансад бүртгэлтэй, 139.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгө, мөн аймгийн Орон нутгийн өмчийн газрын балансад бүртгэлтэй 64.26 сая төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг тус тус төрийн өмчид хүлээн авах, Гадаадын иргэн, харьяатын газрын харьяа Зүүн бүс дэх газарт эзэмшүүлж, бүртгэлд тусгах зөвшөөрөл олгох тухай асуудлыг ТӨБЗГ-ын 2017 оны 461 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. Тогтоолыг холбогдох байгууллагад хүргүүлж хэрэгжүүлсэн. 3. Нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн яамны чиг үүрэг нь нийлсэнтэй холбоотой харьяа байгууллагуудын орон нутгийн өмчийг төрд авах тухай саналыг тухай бүр хүлээн авч, ТӨБЗГ-ын 2017 оны 37 (Өмнөговь), 80 (Дундговь), 97 (Өвөрхангай) дугаар тогтоолоор шийдвэрлэж, хэрэгжүүлсэн. 4. УАГ-ын харьяа Баянхонгор, Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Нийслэлийн аудитын газрын өмчийг төрийн өмчид авах тухай саналыг УАГ-аас Аймаг, нийслэлийн ИТХ-д хүргүүлсний дагуу Сүхбаатар аймгийн ИТХТ-ийн 2017 оны 09, Баянхонгор аймгийн ИТХТ-ийн 2017 оны 119, Өмнөговь аймгийн ИТХТ-ийн 162 дугаар тогтоол тус тус гарч, ТӨБЗГ-т ирүүлээд байна. Бусад (Дорноговь, Нийслэл) аймаг, нийслэлийн шийдвэр гарахаар нэгдсэн журмаар шийдвэрлүүлэхээр бэлтгэл хангаж байна. 5. Өмнөговь аймгийн Сэврэй сумын мод үржүүлгийн газар болон Гурвантэс сумын ЗДТГ-аас, Дорнод аймгийн Баяндун сумын ЗДТГ-ын балансаас цахилгаан дамжуулах агаарын шугам болон үндсэн хөрөнгүүдийг төрд хүлээн авсан. 6. Орон нутгийн төсвийн санхүүжилтээр бий болсон тоног төхөөрөмжийг хүлээн авсан төрийн өмчит хуулийн этгээд нь тухай бүр данс бүртгэлдээ тусгаж байх асуудлыг ТӨБЗГ-ын 86 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хэрэгжүүлж байна. ("Бүрэн хэрэгжсэн" - 100%)
<p>Арга хэмжээ 3.3.34. Дуусаагүй барилга, байгууламжийн талаар авах арга хэмжээг</p>	<ul style="list-style-type: none"> - Захиргааны статистик мэдээллийн 2016 оны улсын нэгтгэлд тусгах дүгнэлт гаргах; - Засгийн газрын 	<p>Тооцоо, судалгааны дүнд холбогдох арга хэмжээг</p>	<p>ТӨБХХ</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн бүх хуулийн этгээдийн дуусаагүй барилга байгууламж бүхий нэгжийн ТӨ-1 нэгтгэлийг хүлээн авч, улсын нэгтгэл хийж боловсруулан Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн. Дуусаагүй барилга байгууламжийн судалгааг 21 аймгийн ОНӨГ болон</p>

<p>тодорхойлон дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах</p>	<p>хуралдаанд танилцуулахад бэлтгэх; - Засгийн газрын шийдвэр гаргуулж, холбогдох арга хэмжээг зохион байгуулах; - III улиралд.</p>	<p>авч хэрэгжүүлсэн байна.</p>		<p>Нийслэлийн өмчийн харилцааны газраас дахин нягталж, нэгдсэн танилцуулга, дүгнэлтийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Сангийн яаманд хүргүүлсэн. ЗГХЭГ-аас ХЗДХЯ, Сангийн яаманд дуусаагүй барилга байгууламжийн судалгааг албан бичгээр хүргүүлж, цаашид тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх чиглэл өгсөн байна. ("Бүрэн хэрэгжсэн" - 100%)</p>
<p>Арга хэмжээ 3.4.35. Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>- Ерөнхий сайдаас байгуулсан Ажлын хэсгийн ажлыг зохион байгуулах; - Дэд ажлын хэсгийг ажиллуулж, холбогдох судалгаа, тооцоог хийж, дүгнэлт гаргах; - ТӨБЗГ-ын саналыг боловсруулан бэлтгэх; - Засгийн газар хоорондын хуралдааны шийдвэр гаргуулах арга хэмжээ авах; - Жилдээ.</p>	<p>Асуудлыг Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулсан байна.</p>	<p>ТӨБХХ</p>	<p>Ерөнхий сайдын 2016 оны 91 дүгээр захирамжаар томилогдсон Ажлын хэсэг Засгийн газар хоорондын 1971, 1979 оны хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулахын тулд харилцан солилцох ноот бичгийн төслийг зөвшилцөж хоёр улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу УИХ, Засгийн газраар хэлэлцүүлэхтэй холбоотой баримт материалыг бүрдүүлж хоёр талын шинжээчдийн болон Ажлын хэсгийн хамтарсан хуралдааныг 3 дугаар сард зохион байгуулсан. Мөн Засгийн газар хоорондын комиссын хуралдаанд Ажлын хэсгийн зүгээс тайлан бэлтгэн танилцуулсан. ОХУ-ын талаас ирсэн шинжээчидтэй хамтран ажиллаж холбогдох үл хөдлөх хөрөнгийн жагсаалт, кадастрын зураг, хаяг авах ажлыг зохион байгуулав. Ажлын хэсэгт ирсэн иргэдийн өргөдөл, гомдол, байгууллагуудын албан бичгийн хариуг бэлтгэн хүргүүлэх, Засгийн газрын болон УИХ-ын холбогдох гишүүдэд танилцуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. ТӨБЗГ-ын даргын тушаалаар Монгол Улс дахь ОХУ-ын өмчийн маргаантай асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулж, Ажлын хэсгийн баримт материал бүрдүүлэх, орон сууцны 8 барилгыг төрийн өмчид авах асуудлыг судалж байна. ("Хэрэгжих шатанд" - 70%)</p>
<p>Арга хэмжээ 3.5.36. Төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины тоо, төрлийг шинэчлэн тогтоох</p>	<p>- Судалгаа хийж, нэгтгэн дүгнэлт гаргах; - Танилцуулга бэлтгэж, ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулах; - Цаашид авах арга хэмжээг тодорхойлж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах; I, II улиралд.</p>	<p>Автомашины тоо, төрлийг шинэчлэн тогтоосон шийдвэр гарч, хэрэгжилтийг хангасан байна.</p>	<p>ТӨБХХ</p>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийт 6942 тээврийн хэрэгслийн судалгаа хийж, тоо төрөл, норм нормативыг шинэчлэн тогтоох асуудлаар Засгийн газрын тогтоолын төслийг бэлтгэж Засгийн газарт хүргүүлсэн. ("Хэрэгжих шатанд" - 70%)</p>
<p>Арга хэмжээ 3.6.37. Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн эд хөрөнгийн</p>	<p>- Орон нутгийн өмчийн газраас мэдээ, тайланг батлагдсан маягтын дагуу хянан</p>	<p>Эд хөрөнгийн асуудлаарх захиргааны статистикийн</p>	<p>ТӨБХХ</p>	<p>Захиргааны статистикийн мэдээллийг хугацаанд нь нэгтгэн боловсруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. 21 аймгийн ОНӨГ, НӨХГ-ын холбогдох мэргэжилтнүүдэд 3 дугаар сард семинар өгч, мэдээ, тайлан хүлээж авах ажлыг гүйцэтгэсэн.</p>

<p>“Захиргааны статистикийн мэдээлэл”-ийг нэгтгэн гаргаж, Үндэсний статистикийн хороонд хүргүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - хүлээж авах; - Нэгтгэлийг боловсруулж, тайлан, танилцуулга бэлтгэх; - Бүх байгууллагыг хамруулсан байх; - Үндэсний статистикийн хороонд хүргүүлэх; - III/15-ны дотор. 	<p>мэдээ, тайлан улсын хэмжээнд нэгтгэгдэн олон нийтэд мэдээлэгдсэн байна.</p>		<p>Орон нутгийн өмчөөс гадна төрийн өмчит байгууллагуудын статистикийн мэдээллийг нэгтгэсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн нийт 5848 байгууллага (нууцын зэрэглэлтэй байгууллагын мэдээллээс бусад)-ын статистикийн мэдээллийг нэгтгэн ТӨБЗГ-ын даргын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А-1/455 дугаар албан бичгээр Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн. Цахим мэдээллийг ҮСХ-ны цахим мэдээллийн санд 3 дугаар сарын 15-ны дотор багтаан оруулсан.</p> <p>(“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 3.7.38. Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан тэнцэл, хөрөнгийн дүн мэдээ, судалгааг нэгтгэн боловсруулж, мэдээллийн сан үүсгэх</p>	<ul style="list-style-type: none"> - Тайланг хүлээн авч нэгтгэн боловсруулах, II-Ү сар; - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 1128, орон нутгийн өмчит 4958 хуулийн этгээдийн хөрөнгийн мэдээллийг нэгдсэн санд оруулж, хэрэглэгчийг мэдээллээр хангах; - Жилийн турш мэдээллийн сангийн баяжилт хийх. 	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл-мэдээллийн сан баяжсан байна. Бүртгэлээр хяналт тавих боломж бүрдэнэ.</p>	<p>ТӨБХХ</p>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 1026 хуулийн этгээдийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэл, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн дүнг хүлээн авч нэгтгэн мэдээллийн санд баяжуулалт хийлээ.</p> <p>21 аймаг, нийслэлийн өмчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн дүн мэдээг хүлээн авч, улсын хэмжээний төрийн өмчийн дүнтэй нэгтгэн улсын нэгдсэн дүнг гаргасан. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 3.8.39. Төрийн өмчийн бүртгэл-мэдээллийн цахим системийг боловсронгуй болгох арга хэмжээ авах</p>	<ul style="list-style-type: none"> - Шаардлагатай хөрөнгийн тооцоо, судалгааг хийх; - Хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, төсөл боловсруулах; - Цахим системийг боловсронгуй болгох төслийг санхүүжүүлэх гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийг судлах; - III-IV улиралд. 	<p>Төрийн өмчийн бүртгэл-мэдээллийн цахим системийг боловсронгуй болгоход шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдсэн байна.</p>	<p>ТӨБХХ, Мэдээллийн технологийн алба (Цаашид “МТА” гэх)</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 128 дугаар тогтоолын дагуу төрийн өмчийн эд хөрөнгийн цахим дуудлага худалдаа системийг хөгжүүлэх технологийн чиг хандлагыг судалж, программ хангамжийн архитектур болон өгөгдлийн сангийн загварыг гарган кодчиллыг бэлэн болгосон. Цахим хэлбэрээр дуудлага худалдаа зохион байгуулах зорилго бүхий мэдээллийн системийг хөгжүүлсэн.</p> <p>Төрийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системийн цаашдын хөгжил, хөгжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулж, удирдлагын түвшинд танилцуулсан. Олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудад уг системийн төслийн санхүүжилтийн дэмжлэг авах талаар хүсэлт явуулсан.</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-ийн хурдыг сайжруулж, уг системтэй холбоотой асуудлаар нийт 29 байгууллагад зөвлөгөө, тусламж үзүүлсэн байна. Системийг ашиглах,</p>

				алдаагаа олж засах талаар зөвлөмж, гарын авлага бэлтгэн цахим мэдээллийн санд байршуулсан. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2015, 2016 оны үндсэн хөрөнгө, газар, бусад мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд оруулсан байдалд хяналт тавьж, программ хангамжийн сургалт, тулгалтын ажлыг бүх аймаг болон нийслэлийн байгууллага бүрт хүрч хийсэн. ("Хэрэгжих шатанд" - 70%)
Арга хэмжээ 3.9.40. Төрийн өмчит хуулийн этгээдийн түрээсийн гэрээг шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Гэрээг холбогдох журам, зааврын дагуу гүйцэтгэсэн байх; - Түрээсийн орлогын 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх, хяналт тавих; - Жилдээ. 	Төрийн өөрийн өмчийн илүүдэлтэй байр, талбайг түрээслүүлж, 500,0 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.	ТӨБХХ	ТӨБЗГ-ын "Түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай" 2016 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн өмчийн түрээсийн гэрээ"-ний дагуу 2017 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт төрийн өмчит 67 хуулийн этгээдийн 402 түрээсийн гэрээг хянан баталгаажуулж, түрээсийн нийт орлогоос улсын төсөвт 2.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна. 2017 онд улсын төсөвт төвлөрүүлсэн түрээсийн орлогыг өнгөрсөн онтой харьцуулахад 544.8 сая байсан бол 2,090.0 сая болж 3.8 дахин нэмэгдсэн бөгөөд Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 2017 оны зорилтот түвшинг бүрэн хангаад байна. Төрийн өмчийг бусдад түрээслүүлэх, түрээслэгчийг сонгон шалгаруулахад үүсч байгаа асуудлыг судлах, хэрхэн шийдвэрлэх талаар санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Газрын даргын 2017 оны А/178 дугаар тушаалаар байгуулан ажиллуулж байна. ("Бүрэн хэрэгжсэн" - 100%)
Арга хэмжээ 3.10.41. Төрийн өмчийн хуулийн этгээдийн ашиглагдахгүй болсон хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдах ажлыг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Дуудлага худалдааны зар, товыг ил тод зарлан мэдээлэх; - Дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх; - Тухай бүр. 	Төрийн өмчийн дуудлага худалдааны дүнд улсын төсөвт 80,0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлнэ.	ТӨБХХ, БТУХ	ТӨБЗГ-ын 2017 оны тогтоолоор авто тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг хууль, журмын хүрээнд зохион байгуулав. Нээлттэй дуудлагын худалдааны зарыг өдөр тутмын хэвлэлд нийтлүүлэн, комисс томилж, ажиллуулав. Нээлттэй дуудлагын худалдааны дүнд нийт 553.7 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн. ("Бүрэн хэрэгжсэн" - 100%)
Арга хэмжээ 3.11.42. Төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлж, шинээр бий болсон хөрөнгийг баталгаажуулах	<ul style="list-style-type: none"> - Тухай бүр асуудлыг судлан боловсруулах; - ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх; - Шийдвэр гаргуулах; - Жилийн туршид, тухай бүр. 	Хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн хөдөлгөөний асуудал шийдвэрлэгдсэн байна.	ТӨБХХ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар 2017 онд давхардсан тоогоор 691 байгууллагын 569903 нэр төрлийн 593.5 тэрбум төгрөгийн хөрөнгийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний зохицуулалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн: <ul style="list-style-type: none"> - 267 байгууллагын 100455 нэрийн 67,364.8 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан; - 89 байгууллагын 579 нэр төрлийн 5,139.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий эд хөрөнгийг худалдаж, 553.8 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн;

				<ul style="list-style-type: none"> - 222 байгууллагын 391821 нэрийн 144,924.0 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, тогтоолын биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж байна; - 13 байгууллагад 139 нэр төрлийн нийт 72,739.9 сая төгрөгийн эд хөрөнгийг шинээр худалдаж авах зөвшөөрөл олгосон; - 100 байгууллагын 76909 нэр төрлийн 303,332.8 сая төгрөгийн эд хөрөнгийг бүртгэж авсан. <p>Гарсан шийдвэрийг хүргүүлэх, хэрэгжүүлэх, тогтоолын биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллав. (“Бүрэн хэрэгжсэн” - 100%)</p>
<p>Арга хэмжээ 3.12.43. “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулах; - Үзлэг, тооллогоор илэрсэн зөрчлийг арилгах ажилд хяналт тавих; - Төрийн өмчит хуулийн этгээдийг удирдамж чиглэл, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангаж ажиллах; - Жилдээ. 	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг, тоологын дүнгийн мөрөөр Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтэд ахиц гарна.</p>	<p>ТӨБХХ</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүнгийн мөрөөр гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. ТӨБЗГ-ын даргын 2017 оны А/110 дугаар тушаалаар дахин үнэлгээний ажлыг 2018 онд зохион байгуулах бэлтгэл хангах Ажлын хэсгийг байгуулж, удирдамжаар ханган ажиллаж байна. Дахин үнэлгээний зардлын төсвийг тооцон боловсруулж, 2018 оны төсөвт тусгуулав. Ажлын хэсгээс төлөвлөгөөний дагуу үнэлгээний ажлын бэлтгэл хангах, аргачлал, зөвлөмж боловсруулах, судалгаа хийх зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ. Зөвлөмжийн дагуу үнэлгээний ажлын бэлтгэл хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэв. 2. ГХЯ-тай хамтран гадаад улс дахь Монгол Улсын төрийн өмчийн үнэлгээний өнөөгийн байдлын талаар судалгааг бэлтгэж, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээ, мэдээллийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна. Мөн Монгол Улсад байгаа гадаадын Дипломат төлөөлөгчийн газруудад түрээсээр ашиглуулж буй барилга байгууламж, тусгай хэрэгцээний газрын судалгааг гаргаж, үнэлгээ хийх бэлтгэл ажлыг хангав. 3. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн өмчлөх эрх болон төрийн байгууллагад хөрөнгө эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх асуудлаар ХЗДХЯ-тай хамтарч санал боловсруулан, танилцуулга бэлтгэж, Ажлын хэсэг болон ХЗДХЯ-нд танилцуулсан. ХЗДХЯ-наас Ажлын хэсгийн саналыг нэгтгэн Засгийн газарт танилцуулаад байна. 4. Үзлэг, тооллогоор илэрсэн зөрчлийг арилгаж бүртгэлгүй хөрөнгийн бүртгэлд тусгах, дутагдсан хөрөнгийг нөхөн төлүүлэх, хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх ажлыг аймаг, нийслэлийн ОНӨГ болон байгууллага бүрт зохион байгуулах талаар арга хэмжээ авч, биелэлтийн тайланг нэгтгэн гаргасан. 5. Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгийг тухай бүр орон нутгийн өмчид бүртгэж байх асуудлыг НӨХГ болон 21 аймгийн ОНӨГ-т хэрэгжүүлэх

				арга хэмжээ аван ажиллаж байна. 6. ТӨБЗГ-аас төв, орон нутагт зохион байгуулсан 2 удаагийн сургалт, семинарын хүрээнд Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх ажлын явцыг хянаж, заавар, зөвлөгөө өгч ажиллав. ("Бүрэн хэрэгжсэн" - 100%)
ХӨТӨЛБӨР ҮҮ "Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалтын үр өгөөжид мониторинг хийх, өмчийн болон санхүүгийн хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах" хөтөлбөрийн хүрээнд:				
Арга хэмжээ 4.1.44. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангах	<ul style="list-style-type: none"> - Хугацаа, хуваарийг тусгасан төлөвлөгөө боловсруулан батлуулах, I сард; - Төлөвлөгөөнд тусгагдсан хяналт шалгалтыг тусгайлсан удирдамжаар гүйцэтгэх; - Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд эдийн засгийн дүн шинжилгээ хийх; - Хяналт шалгалтын дүн, эдийн засгийн дүн шинжилгээний дүгнэлтийн талаар танилцуулга бэлтгэх; - Газрын хуралдаанд танилцуулах асуудал, шийдвэрийн төсөл боловсруулах; - Тухайн бүрд. 	Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулах асуудалд холбогдох хууль тогтоомж, заавар журмыг хэрэгжүүлсэн байна.	ТӨБХХ	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд 2017 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн. 2017 оны хяналт, шалгалт хийх төлөвлөгөөний дагуу төрийн өмчит 32 хуулийн этгээдэд шалгалт хийхээс 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 22 компани, төрийн өмчит 10 үйлдвэрийн газарт шалгалт хийж дууссан. Төрийн өмчит 23 хуулийн этгээдийн шалгалтын дүнг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулсан байна. Төрийн өмчит 9 хуулийн этгээдэд хийсэн шалгалтын дүнг хуралд танилцуулахаар бэлтгэсэн. Шалгалтаар 2016 онд 61.0 тэрбум төгрөгийн, 2017 онд нийт 21.6 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлсэн байна. Тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангуулах зорилгоор зөрчил арилгах, давтан гаргахгүй байх талаар ТӨБЗГ-ын тогтоолоор үүрэг, даалгавар өгч ажилласан. ("Бүрэн хэрэгжсэн" - 100%)
Арга хэмжээ 4.2.45. Шалгалтын дүн мэдээг нэгтгэн, зөрчил доголдол, түүнийг арилгах талаар гарсан тогтоол, шийдвэрийн биелэлтийг тооцох	<ul style="list-style-type: none"> - Шалгалтад хамрагдсан бүх байгууллага, ААН-д өгсөн зөвлөмж, чиглэлд тусгагдсан асуудлын судалгаа гаргах; - Шийдвэр, зөвлөмж, чиглэлийн хэрэгжилтэд хяналт 	Шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, зөвлөмж, чиглэл хэрэгжсэн байна.	ТӨБХХ	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын зөрчил, дутагдлын нэгтгэл, тайлан мэдээг тухай бүр боловсруулан ажиллаж байна. 2016 онд хийсэн шалгалтын мөрөөр зөрчил, дутагдлыг арилгасан байдалд мониторинг хийх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллав. ТӨБЗГ-ын хуралдаанд мониторингийн дүнг танилцуулж, төрийн өмчит хуулийн этгээдийн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж ажилласан байдалд үнэлгээ өгөв. 2017 оны төлөвлөгөөний дагуу шалгалт хийсэн байгууллагуудад үнэлгээ,

	тавьж, биелэлтийг нэгтгэн гаргах; - Дүгнэлт, танилцуулга, мэдээлэл бэлтгэх; - Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх; - XII сард.			хяналт шинжилгээ хийх зорилгоор мониторингийн шалгалт хийгдэх шатанд байна. Илэрсэн зөрчил, дутагдлын хэмжээ, шалтгаан үр дагавар, хор хохирол, зөрчил давтагдсан эсэхийг судлан, зөрчил, дутагдлыг арилгах хугацаа заан өгч, давтан гаргахгүй байх, үр ашгийг дээшлүүлэх талаар тодорхой үүрэг даалгаврыг газрын хурлын шийдвэрээр өгч, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. (“Хэрэгжих шатанд” - 70%)
Гурав. “Худалдан авах ажиллагааг төлөвлөн батлагдсан төсвийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулах, тайлагнах” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:				
ХӨТӨЛБӨР Ү “Худалдан авах ажиллагааны хууль, эрх зүйн орчныг сайжруулж, олон улсын хөгжлийн чиг хандлагыг судлан, худалдан авах ажиллагааны чадавхийг бэхжүүлэн цахим худалдан авах ажиллагааг боловсронгуй болгох” хөтөлбөрийн хүрээнд:				
Арга хэмжээ 5.1.46. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тусгах санал боловсруулах	<ul style="list-style-type: none"> - Ажлын хэсэг байгуулах; - Хуулийн төсөлд тусгах санал боловсруулах; - Хуулийн төсөлд тусгах саналыг холбогдох, байгууллага, оролцогчдоос авах ажлыг зохион байгуулах; - Саналыг Сангийн яаманд хүргүүлэх; - Эхний хагас жилд. 	Худалдан авах ажиллагааны хууль эрх зүйн орчин боловсронгуй болно.	ЗХЗХ, Худалдан авах ажиллагааны хэлтэс (Цаашид “ХААХ” гэх)	Худалдан авах ажиллагааны хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 28 дугаар захирамжаар байгуулагдсан Шилэн тендерийн хуулийн төсөл боловсруулах асуудлыг судлах, хуулийн үзэл баримтлал, төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг, Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа “Засгийн газрын худалдан авах ажиллагааг бэхжүүлэх” техникийн туслалцааны төслийн хүрээнд Сангийн сайдын 2017 оны 176 дугаар тушаалаар байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг, мөн Сангийн яамнаас байгуулагдсан Ерөнхий гэрээ байгуулах журмын төсөл, түүний тендерийн жишиг баримт бичиг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл тус тус томилогдон ажиллаж, холбогдох судалгаа, шинжилгээ хийхэд оролцож, саналаа тусган ажиллав. Ажлын хэсгийн гишүүдэд худалдан авах ажиллагааны салбар, эрх зүйн баримт бичгийн талаар мэдээлэл өгч, нийт 8 зүйл бүхий хуулийн төслийг боловсруулахад оролцов. Ерөнхийлөгчийн Тамгын газраас 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан хэлэлцүүлэгт ТӨБЗГ-ын холбогдох албан хаагчид оролцож, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаатай холбоотой гардаг гомдол, түүний шийдвэрлэлт, худалдан авах ажиллагаанд дотоодын үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг дэмжих, дотоодын давуу эрхийг тооцох асуудлаар мэдээлэл, санал солилцож, цаашид авах арга хэмжээний талаар асуудал дэвшүүлэн байр сууриа илэрхийлэв.

				Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулсан Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлэлцүүлэгт ТӨБЗГ-аас төлөөлөл оролцож, саналаа өгсөн. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)
Арга хэмжээ 5.2.47. “Цахим тендер шалгаруулах журам”-ын төсөл, холбогдох бусад журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулах	<ul style="list-style-type: none"> - “Цахим тендер шалгаруулах журам”-ын төсөлд тусгах санал боловсруулах; - Холбогдох бусад журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулах; - Саналыг Сангийн яаманд хүргүүлэх; - I-II улиралд. 	Цахим худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх зүйн орчин тодорхой болно.	ХААХ, МТА	Сангийн яаманд байгуулагдсан Ерөнхий гэрээ байгуулах журмын төсөл, түүний тендерийн жишиг баримт бичиг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (ТӨБЗГ)-ын төлөөлөл томилогдон ажиллаж, журмын төсөлд саналаа тусган ажиллав. Тайлант онд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас дараах журам, жишиг баримт бичгийн төсөлд тусгах санал боловсруулан, холбогдох байгууллагад хүргүүлсэн: <ul style="list-style-type: none"> - Ерөнхий гэрээ байгуулах журам; - Тендерийн жишиг баримт бичгүүд; - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам; - Цахим худалдан авах ажиллагаа зохион байгуулах журам; - Худалдан авах ажиллагааны урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам. Эдгээрээс “Ерөнхий гэрээ байгуулах журам” Сангийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 234 дүгээр тушаалаар, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 363 дугаар тушаалаар шинэчлэгдэн батлагдсан байна. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)
Арга хэмжээ 5.3.48. “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулах	<ul style="list-style-type: none"> - Журмын төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах; - Төсөлд холбогдох байгууллагаас санал авах; - Төслийг цахим хуудсанд байршуулан олон нийтээс санал авах; - Төслийн саналыг Сангийн яаманд хүргүүлэх; - III-IV сард. 	Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалт тодорхой болно.	ЗХЗХ, ХААХ, Ажлын хэсэг	“Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам”-ыг шинээр боловсруулаагүй байна. (“Хэрэгжээгүй” – 0)
Арга хэмжээ 5.4.49. Төсвийн урсгал зардлаар санхүүждэг байнгын хэрэгцээт	<ul style="list-style-type: none"> - Журам, жишиг баримт бичгийн төсөлд тусгах санал боловсруулах; - Төслийг цахим 	Ерөнхий гэрээ байгуулан худалдан авах бараа, ажил,	ХААХ, ЗХЗХ	Сангийн яаманд байгуулагдсан Ерөнхий гэрээ байгуулах журмын төсөл, түүний тендерийн жишиг баримт бичиг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (ТӨБЗГ)-ын төлөөлөл томилогдон ажиллаж, журмын төсөлд саналаа тусган ажиллав.

<p>бараа, бүтээгдэхүүнийг Ерөнхий гэрээгээр худалдан авах журам, жишиг баримт бичгийн төсөлд тусгах санал боловсруулах</p>	<p>хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлэн санал авах; - Төсөлд тусгах саналыг Сангийн яаманд хүргүүлэх; - II улиралд.</p>	<p>үйлчилгээний эрх зүйн зохицуулалт тодорхой болно.</p>		<p>“Ерөнхий гэрээ байгуулах журам” Сангийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 234 дүгээр тушаалаар батлагдсан. ("Бүрэн хэрэгжсэн" – 100%)</p>
<p>Арга хэмжээ 5.5.50. Дотоодын давуу эрхийн зөрүү тооцох аргачлал, журмыг тодорхой болгох асуудлаар санал боловсруулах</p>	<p>- Аргачлал, журмын төсөлд тусгах санал боловсруулах; - Саналын төслийг Сангийн яаманд хүргүүлэх; - II улиралд.</p>	<p>Худалдан авах ажиллагааны журмын зохицуулалт сайжирна.</p>	<p>ХААХ</p>	<p>“Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ын төсөлд өгөх саналыг нэгтгэн боловсруулж, 2017 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/14 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. ("Бүрэн хэрэгжсэн" – 100%)</p>
<p>Арга хэмжээ 5.6.51. 2018 онд зохион байгуулах улсын болон бүс нутгийн чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, Ерөнхий гэрээгээр 2018 онд худалдан авах барааны жагсаалт батлуулах</p>	<p>- Захиалагчаас санал авч нэгтгэх; - Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгуулах; - Засгийн газрын шийдвэр, жагсаалтын төсөл боловсруулах; - Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах; - XI сард.</p>	<p>Хуулийн хугацаанд багтаан жагсаалтыг батлуулсан байна.</p>	<p>ХААХ</p>	<p>Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ТӨБЗГ-т зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтыг батлуулах арга хэмжээ авав. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн ХЭГ/1756 дугаар албан бичгийг төсвийн 16 ерөнхийлөн захирагчид хүргүүлэн ТӨБЗГ-т зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтад тусгах саналыг авч нэгтгэн, Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэв. Засгийн газрын 2017 оны 135 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2018 онд зохион байгуулагдах худалдан авах ажиллагааны жагсаалт батлагдсан. Уг жагсаалтад тусгагдсаны дагуу 2018 онд ТӨБЗГ-аас нийт 835.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 547 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, мөн зарим ерөнхий нэршлийн эмийг “Ерөнхий гэрээ байгуулах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулна. ("Бүрэн хэрэгжсэн" – 100%)</p>
<p>Арга хэмжээ 5.7.52. 2018 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулах</p>	<p>- Батлагдсан жагсаалтад тусгагдсан төсөл, арга хэмжээ бүрийг тусгасан тухайн Төсвийн ерөнхийлөн захирагч нар, ТӨБЗГ-ын хамтарсан төлөвлөгөө батлах; - 2018 онд ТӨБЗГ-аас зохион байгуулах худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг батлуулах; - Зохион байгуулах төсөл,</p>	<p>Хуулийн хугацаанд багтаан хэрэгжүүлсэн байна.</p>	<p>ХААХ</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 315 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2018 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтад тусгагдсан төсөл, арга хэмжээний захиалагч - Төсвийн ерөнхийлөн захирагчидтай ТӨБЗГ-ын хамтарсан төлөвлөгөөг нарийвчилж, батлуулахаар төслийг бэлтгэн 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 1/3494 дүгээр албан бичгээр холбогдох захиалагчдад хүргүүлээд байна. Захиалагчдаас ирүүлэх саналыг нэгтгэж, 2018 онд ТӨБЗГ-аас зохион байгуулах худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг батална. ("Хэрэгжих шатанд" - 70%)</p>

	<p>арга хэмжээний ажлын даалгавар, зураг төслийг захиалагчаас хүлээн авч, худалдан авах ажиллагааны бэлтгэлийг хангах;</p> <p>- XI сард.</p>			
<p>Арга хэмжээ 5.8.53. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон гадаадын бусад донор байгууллагуудтай хамтран ажиллах</p>	<p>- Цаашид хамтран ажиллах тухай албан бичиг төлөвлөн, хүргүүлэх;</p> <p>- Дэлхийн банкны санхүүжилтээр “Ухаалаг засаг” төслийн хүрээнд хэрэгжих 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах;</p> <p>- Тухай бүр.</p>	<p>Гадаадын хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний худалдан авалт бүрэн хийгдэж, гэрээ байгуулсан байна.</p>	<p>ХААХ</p>	<p>Худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банктай хамтран ажиллаж, худалдан авах ажиллагааны болон байгууллагын албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын сургалтад давхардсан тоогоор нийт 41 мэргэжилтнийг хамруулж, эдгээр донор байгууллагын санхүүжилттэй хэрэгжиж байгаа зарим худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т зохион байгуулах зэргээр хамтран ажиллаж байна. Дэлхийн банкны “Монгол, Вьетнам Улс дахь төрийн худалдан авах ажиллагааны статистикийг бэхжүүлэх төсөл”-ийн санхүүжилтээр “Худалдан авах ажиллагааны цахим систем”-ийн болон Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтыг 21 аймагт зохион байгуулсан.</p> <p>Дэлхийн банкны санхүүжилтээр “Ухаалаг засаг” төслийн хүрээнд хэрэгжих 2.3 сая ам.доллар (ханшаар хөрвүүлсэн дүн - 5.6 тэрбум төгрөг)-ын төсөвт өртөг бүхий 7 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т тайлант жилд зохион байгуулж байна. Хэрэгжилтийн явцыг 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар дор тодорхой дурдвал,</p> <ol style="list-style-type: none"> 1. 2,656.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан (хэрэгжсэн); 2. 240.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээний тендерийг зарласан, нээлт хийх болоогүй (хэрэгжих шатандаа); 3. 2,592.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээний тендерийг нээсэн, үнэлгээ хийж байгаа (хэрэгжих шатандаа); 4. 144.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, холбогдох материалыг захиалагчаас ирүүлээгүй байгаа тул хэрэгжээгүй хүлээгдэж байна. <p>Дэлхийн банкны санхүүжилтээр 2,656.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 багц ажлын гэрээг 2,608.4 сая төгрөгөөр байгуулж 48.4 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.</p> <p>Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж байгаа “Засгийн газрын худалдан авах ажиллагааг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд 5 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлыг шинээр эхлүүлэхээр үнэлгээний хороог 12 дугаар сард байгуулаад байна.</p> <p>Цаашид, дээрх 2 донор байгууллагын санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т зохион байгуулах</p>

				боломжтой талаарх саналаа эдгээр байгууллагад албан ёсоор илэрхийлээд байна. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)
<p>Арга хэмжээ 5.9.54. Аймаг, нийслэл, дүүргүүдэд цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн сургалт, Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалт зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Бэлтгэл хангуулах; - Дэлхийн банкны санхүүжилтээр Сангийн яам, ТББ-тай хамтран сургалт зохион байгуулах; - Онлайн болон бусад хэлбэрээр шалгалт авч, гэрчилгээ олгох; - Эхний хагас жилд, 21 удаа. 	<p>Орон нутагт худалдан авах ажиллагаа зохион байгуулах чадавх дээшилнэ. Улсын хэмжээнд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны 60-аас доошгүй хувийг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.</p>	<p>МТА, ХААХ, ЗХЗХ</p>	<p>Дэлхийн банкны “Монгол, Вьетнам Улсын худалдан авах ажиллагааны статистикийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд “Цахим худалдан авах ажиллагааны системийн хэрэглэгчийн чадавхийг сайжруулах сургалт”-ыг Дэлхийн банкны 200.0 сая төгрөгийн санхүүжилт, дэмжлэгтэйгээр улсын хэмжээнд 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс эхлүүлэн Сангийн яамтай хамтран үе шаттайгаар зохион байгуулж дуусав. Тайлант онд буюу 2017 оны 01 дүгээр сараас 05 дугаар сарыг дуусталх хугацаанд 21 аймагт төрийн худалдан авах ажиллагааны захиалагч, нийлүүлэгч талын төлөөллүүдийг бүрэн хамруулав. “Цахим худалдан авах ажиллагаа”-ны захиалагчид зориулсан сургалтад 802, нийлүүлэгчид зориулсан сургалтад 749 иргэн хамрагдаж худалдан авах ажиллагааны системийг ашиглах чадвартай болсон. “Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох” сургалтад аймаг, сумдын төрийн байгууллагын албан хаагчид, мэргэжлийн холбоодын төлөөлөл, иргэн нийт 1629 хүн хамрагдаж, 837 хүн шалгалтанд тэнцэж “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалт”-ын гэрчилгээтэй болсон. Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтад хамрагдагсдаас “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ийн “Цахим шалгалт” дэд системээр дамжуулан шалгалт авч, гэрчилгээ олгож ажилласан. Энэхүү системээр 2017 онд (12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар) нийт 446 шалгалт зохион байгуулагдаж, 7533 хүн шалгалт өгснөөс 4094 хүн худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ авсан байна. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн (гэрчилгээ авсан) нийт 9419 хүн бүртгэлтэй байна. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 5.10.55. Төрийн өмчит аж ауйн нэгжид худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээ авч, мэргэжил, арга зүйн</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, ТӨҮГ-уудыг албан хаагчдад хуваарилан хариуцуулах зохион байгуулалтыг хийх; 	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, ТӨҮГ-уудын зохион байгуулж</p>	<p>ХААХ, МТА</p>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, ТӨҮГ-ын 2017 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” https://tender.gov.mn/mn/plan/ -нд байршуулах, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдэд</p>

удирдлагаар хангах	<ul style="list-style-type: none"> - Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хүлээн авч, цахим системд байршуулах; - Зөвлөгөө, арга зүйгээр хангаж, сургалт, семинар зохион байгуулах; - Худалдан авах ажиллагаанд хяналт тавих; - Жилд. 	байгаа худалдан авах ажиллагаанд тавих хяналт сайжирна.		<p>хариуцуулан, ажил үүргийн хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулан ажиллав. Нийт захиалагч байгууллагуудад тус системийн ашиглалт, ач холбогдол, шаардлагуудын тухай мэдээллийг хүргэн, цахим болон цахим бус тендер шалгаруулалтын талаарх заавар, зөвлөмжийг утсаар, цахимаар болон уулзалтын хэлбэрээр хүргэж, зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн. Төрийн мэдээлэл холбооны шугам бүхий албаны утсаар 6349 удаагийн дуудлага хүлээн авч, харилцсан бөгөөд 14840 минут үргэлжилсэн зөвлөгөөг өгсөн байна.</p> <p>Мөн долоо хоног бүрийн Мягмар гаригт 10 цагаас захиалагч байгууллагын төлөөлөлд тогтмол сургалт явуулж, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэн ажиллаж байна. Зарим байгууллагуудын хүсэлтээр нийт 75 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 1300 захиалагч байгууллагын төлөөллийг хамруулсан байна.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 100 аж ахуйн нэгж, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газарт “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-тэй ажиллахдаа анхаарах асуудлын талаарх зөвлөмж, чиглэлийг 04 дүгээр сарын 13-ны өдрийн А-1/759 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>“Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” https://tender.gov.mn –нд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 87 аж ахуйн нэгжийн 3654 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа төлөвлөгдсөн, 964 тендерийн урилга нийтлэгдсэнээс цахим тендер шалгаруулалтын 257 урилга байна. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>ХӨТӨЛБӨР ҮИ “Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулж, мэдээллийн санг бүрдүүлэн баяжуулах” хөтөлбөрийн хүрээнд:</p>				
<p>Арга хэмжээ 6.1.56. Засгийн газрын 2016 оны 152 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээ болон захиалагчаас эрх шилжиж ирсэн ажлуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Үнэлгээний хороо байгуулах; - Худалдан авах ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулах; - Шаардлагад нийцсэн тендерт оролцогчтой хуулийн хугацаанд гэрээ байгуулах; - Тендер шалгаруулалтын ил тод байдлыг хангаж 	Худалдан авах ажиллагаа хуулийн хугацаанд хууль, журам, зааврын дагуу зохион байгуулагдсан байна.	ХААХ	<p>Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 152 дугаар тогтоолоор 2017 онд ТӨБЗГ-т зохион байгуулагдах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны жагсаалт батлагдсан. Уг жагсаалтад тусгагдсаны дагуу ТӨБЗГ-т улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 61.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 30 төсөл, арга хэмжээний 55 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Түүнчлэн, 6 Төсвийн Ерөнхийлөн захирагч (ХЗДХЯ, БОНХАЖЯ, ЭМЯ, БСШУСЯ, ЗТХЯ, МХЕГ)-аас эрх шилжүүлж ирүүлсэн 11.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 25 төсөл, арга хэмжээний 42 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.</p> <p>ТӨБЗГ-т 2017 онд зохион байгуулагдаж байгаа улсын төсвийн хөрөнгө</p>

	ажиллах; - ҮИ/01-ний дотор.			<p>оруулалтаар хэрэгжүүлэх нийт 72.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 55 төсөл, арга хэмжээний 97 багц ажлын худалдан авах ажиллагааны явцыг дор харуулав, (2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар):</p> <ol style="list-style-type: none"> 1. Гэрээ байгуулсан - 58 багц ажил; 2. Захиалагчид зөвлөмж хүргүүлсэн – 1 багц ажил; 3. Гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн - 3 багц ажил; 4. Захиалагчид буцаасан - 9 багц ажил; 5. Тендер зарласан, нээлт хийх болоогүй - 7 багц ажил; 6. Тендерийн нээлт хийсэн, үнэлгээ хийж буй – 14 багц ажил; 7. Техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг захиалагчаас ирүүлээгүй – 2 багц ажил; 8. Хүчингүй болсон - 3 багц ажил. <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих нийт 32.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 58 багц ажлын худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсний үр дүнд нийт 27.2 тэрбум төгрөгийн гэрээг гүйцэтгэгчтэй байгуулж, 2.8 тэрбум төгрөгийн улсын төсвийн хэмнэлт гаргасан байна. (“Хэрэгжих шатанд” – 70%)</p>
<p>Арга хэмжээ 6.2.57. 2017 онд Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах</p>	<p>- Холбогдох яам, агентлагаас Ерөнхий гэрээгээр худалдан авах 4 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний судалгааг авах;</p> <p>- Ерөнхий гэрээгээр худалдан авах барааны тендерийн баримт бичгийг боловсруулан худалдан авалтыг цахим хэлбэрээр зохион байгуулна;</p> <p>- III улиралд худалдан авах ажиллагааг зохион байгуулж эхлэх.</p>	<p>2017 онд ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, бүтээгдэхүүний нийлүүлэгч тодорхой болж, нийлүүлсэн барааг “Цахим дэлгүүр”-ээс худалдан авсан байна.</p>	<p>ХААХ</p>	<p>Сангийн яамнаас Ерөнхий гэрээ байгуулах журам, тендерийн жишиг баримт бичгийн төсөл боловсруулж, батлуулахтай холбоотойгоор Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 152 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Ерөнхий гэрээ байгуулан худалдан авах 4 төрлийн бараа бүтээгдэхүүний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй.</p> <p>Дээрх журам, тендерийн жишиг баримт бичгийн төсөлд санал боловсруулж тусгахаар Сангийн яаманд байгуулагдсан Ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл томилогдон ажилласан. (“Хэрэгжилт хангалтгүй” – 30%)</p>
<p>Арга хэмжээ 6.3.58. 2017 онд зохион байгуулах тендерийн урилга, зарыг нийтлүүлэх өдөр тутмын сонинг сонгон</p>	<p>- Ажлын хэсэг байгуулах;</p> <p>- Нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулж, ил тод мэдээлэх, I сард;</p>	<p>Тендерийн урилга, зар, мэдээлэл олон нийтэд хүртээмжтэй, ил тод</p>	<p>ХААХ, Ажлын хэсэг</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2017 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендерийн урилгыг нийтлүүлэх өдөр тутмын 3 хүртэлх сонинг сонгон шалгаруулах дотоодын нээлттэй тендерийг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог Газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/5 дугаар тушаалаар байгуулан ажиллуулсан. (Үнэлгээний хорооны даргаар ХААХ-ийн дарга Х.Улам-</p>

шалгаруулах	<ul style="list-style-type: none"> - Зохион байгуулагдаж буй төсөл, арга хэмжээний урилга, зарыг хуулийн хугацаанд шуурхай мэдээлэх; - Урилга нийтлүүлсэн өдөр тутмын сонин хэвлэлээр хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгөх; - Жилдээ. 	мэдээлэгдэнэ.		<p>Өрнөх, нарийн бичгийн даргаар мэргэжилтэн С.Чинбат) Тендерийн нээлтийг 2017 оны 02 дугаар сарын 19-ний өдөр хийсэн бөгөөд Өдрийн сонин, Өнөөдөр, Ардчилал сонин тус тус тендер ирүүлснээс Өдрийн сонин, Өнөөдөр сонин шалгарч, гэрээ хийн хамтран ажиллаж байна.</p> <p>Тендерийн урилга болон зөвлөх үйлчилгээний зарыг хариуцсан нарийн бичгийн дарга нар гэрээ хийсэн өдөр тутмын сонинд болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын www.pcsp.gov.mn цахим хуудас, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn – д тухай бүр хугацаанд нь мэдээлэн, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 6.4.59. 2017 онд зохион байгуулах тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд ажиллах Төрийн бус байгууллага болон мэргэжлийн холбоодын шинэчилсэн бүртгэл хийх</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын шинэчилсэн бүртгэл хийх зарыг байгууллагын цахим хуудас болон сониноор зарлах; - Үнэлгээний хороонд ажиллах төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодыг зохих журмын дагуу сонгон шалгаруулах; - Шинээр бүртгэгдсэн ТББ-ын төлөөлөлтэй хамтран ажиллах гэрээ байгуулах; - I сард. 	Тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд олон нийтийн хяналтыг сонгон нээлттэй шалгаруулалтын үндсэн дээр хийлгэсэн байна.	ХААХ, ЗХЗХ	<p>Худалдан авах ажиллагааны хэлтсээс тендер шалгаруулалтын ил тод байдлыг хангах, олон нийтийн хөндлөнгийн хяналтыг сайжруулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зорилгоор төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөллийг тогтмол оролцуулж байна.</p> <p>2017 онд 30 төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын 57 төлөөлөлтэй худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хамтран ажиллахаар гэрээ байгуулсан. Нийт 68 төсөл, арга хэмжээний 109 багц ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах нийт 64 үнэлгээний хороо ТӨБЗГ-т байгуулагдсан бөгөөд тэдгээрт Төрийн бус байгууллагын давхардсан тоогоор 128 төлөөлөл ажиллаж байна. Үнэлгээний хорооний гишүүнээр томилогдон ажилласан ТББ, мэргэжлийн холбоодын 49 гишүүнд 5.3 сая төгрөгийн урамшуулал олгосон.</p> <p>(“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 6.5.60. ТӨБЗГ болон орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжүүдийн 2017 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулж,</p>	<ul style="list-style-type: none"> - Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ТӨБЗГ-ын болон цахим худалдан авах ажиллагааны цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлэх; - Тендер шалгаруулалтын ил 	Улсын хэмжээнд зохион байгуулагдах худалдан авах ажиллагааны нэгдсэн сан бий болж, худалдан авах ажиллагааны	ХААХ, ЗХЗХ, МТА	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 онд зохион байгуулах нийт 56 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын цахим хуудас www.pcsp.gov.mn, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д тус тус байршуулан олон нийтэд ил тод мэдээлж, тендер оролцох боломжоор хангасан.</p> <p>Мөн орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжүүдийн зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендер шалгаруулалтын үр дүнг ил тод мэдээлэх, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд төлөвлөгөөг нийтлэх талаар зөвлөгөө, арга</p>

тендер шалгаруулалтын ил тод байдлыг хангах	тод байдлыг хангаж байгаа байдалд хяналт тавих; - I сард.	талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдсан байна.		зүйгээр ханган ажилласан. 2017 онд 21 аймгийн Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, 9 дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд нийт дүнгээр 112.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1063 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа төлөвлөгдсөн. Орон нутгийн 31 нэгжид зохион байгуулах Төсвийн ерөнхийлөн захирагч нарын баталсан 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын www.pcsp.gov.mn , төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn , тухайн аймаг, нийслэл, дүүргийн цахим хуудсуудад байршуулан мэдээллийн ил тод байдлыг хангасан. ("Бүрэн хэрэгжсэн" – 100%)
Арга хэмжээ 6.6.61. Тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх	- Гэрээ байгуулсан ажлын үр дүнг тухай бүр цахим хуудсанд нийтлэх; - Гэрээ байгуулсан ААН-ийн бүртгэлийг байгууллагын цахим хуудсанд ил тод байршуулах; - Худалдан авах ажиллагааны явц, үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх; - Жилдээ.	Худалдан авах ажиллагааны нээлттэй байдал хангагдсан байна.	ХААХ, МТА	Тендерийн урилга, зарыг гэрээ байгуулсан өдөр тутмын Өдрийн сонин, UB post сонин, www.pcsp.gov.mn , www.tender.gov.mn цахим хуудсанд тус тус нийтлүүлэн, тендерийн нээлт, гэрээ байгуулсан үр дүнг цахим хуудсанд байршуулж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг ханган ажилласан. 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар нийт 67 төсөл, арга хэмжээний урилга, тендерийн нээлт, үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсанд ил тод мэдээлсэн байна. ("Бүрэн хэрэгжсэн" – 100%)
Арга хэмжээ 6.7.62. 2016 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн боловсруулах	- Зохион байгуулсан худалдан авах ажиллагааны нэгдсэн тайланг нэгтгэх; - Дүгнэлт, дүн шинжилгээ бүхий тайланг боловсруулах; - Тайланг Сангийн яаманд хүргүүлэх; - Байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд ил тод мэдээлэх; - I/15-ны дотор.	Худалдан авах ажиллагааны тайлан мэдээг хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад тайлагнасан байна.	ХААХ	ТӨБЗГ-аас худалдан авах ажиллагааны тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд нь Сангийн яаманд хүргүүлсэн: - 2016 онд зохион байгуулсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тайланг Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/66 тоот албан бичгээр; - 2017 оны 1 дүгээр улирлын худалдан авалтын тайланг 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А-1/1655 дугаар албан бичгээр; - 2017 оны худалдан авах ажиллагааны эхний хагас жилийн тайланг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А-2/1697 дугаар албан бичгээр; - 2017 оны худалдан авах ажиллагааны 3 дугаар улирлын тайланг 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А-1/2651 дугаар албан бичгээр тус тус Сангийн яаманд хүргүүлсэн.

<p>Арга хэмжээ 6.8.63. Орон нутгийн нэгжийн 2017 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, тайланг нэгтгэх</p>	<ul style="list-style-type: none"> - Мэдээ, тайланг нэгтгэн боловсруулах; - Удирдлагад танилцуулах; - Нэгдсэн мэдээ, мэдээлэл, тайланд оруулж, тайлагнан мэдээлэх; - Байгууллагын цахим хуудсаар ил тод мэдээлэх; - Улиралд. 	<p>Орон нутагт зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны үр дүнгийн мэдээлэл тодорхой болж, мэдээллийн ил тод байдлыг хангасан байна.</p>	<p>3Х3Х</p>	<p>(“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p> <p>Тайланг хугацаанд 21 аймгийн Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, 9 дүүргийн худалдан авах ажиллагааны албаны 2016 оны 4 дүгээр улирал, 2017 оны 1, 2, 3 дугаар улирлын худалдан авалтын тайланг дээрх 31 нэгжээс хүлээн авч, нэгдсэн дүн мэдээг гаргасан.</p> <p>2017 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 387 тэрбум төгрөгийн 2441 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн байна. Улсын төсвийн хөрөнгөөр 73.1 тэрбум төгрөгийн 468 төсөл, арга хэмжээ, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 230.9 тэрбум төгрөгийн 1031 төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 44.3 тэрбум төгрөгийн 683 төсөл, арга хэмжээ, байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар 5 тэрбум төгрөгийн 90 төсөл, арга хэмжээ, замын сангийн хөрөнгө оруулалтаар 5.1 тэрбум төгрөгийн 68 төсөл, арга хэмжээ, бусад хөрөнгө оруулалтаар 28.6 тэрбум төгрөгийн 101 төсөл, арга хэмжээ санхүүжигдэн хэрэгжихээр байна.</p> <p>Нийт төсөл, арга хэмжээний 91.0 хувь буюу 368.5 тэрбум төгрөгийн 2301 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан, 1 хувь буюу 2.7 тэрбум төгрөгийн 23 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичиг боловсруулагдаж байгаа, 8 хувь буюу 15.8 тэрбум төгрөгийн 117 төсөл, арга хэмжээ тодотголоор хасагдсан болон зураг төсөв, ажлын даалгавар байхгүй гэсэн шалтгаанаар зохион байгуулагдаагүй байна. Зохион байгуулагдсан 368.5 тэрбум төгрөгийн 2301 төсөл, арга хэмжээнээс 346.3 тэрбум төгрөгийн 2164 (86%) төсөл, арга хэмжээний гэрээ байгуулагдаж, 9.7 тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан.</p> <p>21 аймгийн Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар, 9 дүүргийн худалдан авах ажиллагааны албадын худалдан авах ажиллагааны 2017 оны 4 дүгээр улирлын тайлан, мэдээг 2018 оны 1 дүгээр сарын 5-ны дотор хүлээн авч, 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор нэгтгэл хийхээр төлөвлөж байна.</p> <p>(“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Дөрөв. “Захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээлэл, технологийн хөгжлийг хангах” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</p>				
<p>ХӨТӨЛБӨР ҮИ “Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаа, худалдан авах ажиллагаанд хууль эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, бүтцийн нэгжүүдийн уялдаа холбоог хангаж, захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд:</p>				

<p>Арга хэмжээ 7.1.64. Холбогдох хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоход чиглэсэн санал боловсруулж, дээд шатны байгууллагад өргөн барих, саналаа өгөх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах</p>	<ul style="list-style-type: none"> - Санал боловсруулах ажлын хэсэг байгуулах; - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, Шилэн тендерийн тухай хуулийн үзэл баримтлалын төсөл зэрэгт тусгах саналыг нэгтгэн боловсруулах ажлыг зохион байгуулалтаар хангах; - ЗГХЭГ, Хууль зүйн яам, Сангийн яамнаас байгуулсан холбогдох ажлын хэсэгт байгууллагын төлөөллийг оролцуулах; - Хуулийн төсөлд тусгах саналын хэлэлцүүлгийг үе шаттай зохион байгуулах; - Саналын хууль, эрх зүйн үндсийг хянаж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх; - Эхний хагас жилд. 	<p>Байгууллагын үйл ажиллагааны стратегийн зорилго, чиглэлийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн зохицуулалт тодорхой болсон байна.</p>	<p>ЗХЗХ, Ажлын хэсэг</p>	<p>Салбарын хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох болон байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх журам, дүрэм, зааврыг шинэчлэн боловсруулах, холбогдох байгууллагад санал хүргүүлэх чиглэлээр нийт 21 хууль тогтоомж, эрх зүйн актын төслийг боловсруулсан байна.</p> <p>Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар дараах хууль тогтоомжийн төслийг боловсруулж, холбогдох байгууллагад саналаа хүргүүлэн, зарим ажлын хэсэгт байгууллагын төлөөллийг ажиллуулсан:</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, холбогдох 22 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал; - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал; - Шилэн тендерийн тухай хуулийн үзэл баримтлалын төсөлд санал; - Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд санал. <p>Худалдан авах ажиллагаатай холбоотой дараах журмын төсөлд санал боловсруулж өгсөн:</p> <ul style="list-style-type: none"> - Ерөнхий гэрээ байгуулах журам; - Тендерийн жишиг баримт бичгүүд; - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам; - Цахим худалдан авах ажиллагаа зохион байгуулах журам; - Худалдан авах ажиллагааны урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам. <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны чиг үүрэгтэй холбоотой дараах журмуудыг батлан мөрдүүлэв:</p> <ul style="list-style-type: none"> - “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”; - “Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам”; - “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулах тухай” ТӨБЗГ-ын 2017 оны 53 дугаар тогтоол батлагдаж, төрийн өөрийн өмчийн түрээсийн асуудлын зохицуулалтыг тодорхой болгов; - “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”; - “Төрийн өөрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам”. <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2016 оны 9</p>
---	---	--	------------------------------	--

				<p>дүгээр сарын 12-ны өдрийн А/02 дугаар тушаалаар байгуулагдсан газрын дотоод үйл ажиллагаанд хэрэглэгдэх хөтөлбөр, журам, дүрэм, зааврыг шинэчлэн боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн 2017 оны төлөвлөгөөний дагуу дараах журам, дүрэм, зааврыг боловсруулан мөрдүүлэв:</p> <ul style="list-style-type: none"> - “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн заавар”; - “Даргын зөвлөлийн ажиллах журам”; - “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”; - “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр”; - “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шагналын журам”; - “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид тусламж, тэтгэмж, нөхөн олговор олгох журам”; - “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”. <p>(“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 7.2.65. Газрын даргын зөвлөлийн ажиллах журмыг боловсруулах, батлах</p>	<ul style="list-style-type: none"> - Даргын зөвлөлийг байгуулж, ажиллах журмын төслийг боловсруулах; - Газрын даргын тушаалаар батлах, II сард; - Хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, жилдээ. 	<p>Газрын даргын шийдвэрлэх асуудалд мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.</p>	3Х3Х	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах болон байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой асуудлаар газрын даргад мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий зөвлөлийг Газрын даргын 2017 оны А/02 дугаар тушаалаар батлав. Даргын зөвлөлийн ажиллах журмын төслийг боловсруулж, албан хаагчдаас санал авч тусган Газрын даргын 2017 оны А/20 дугаар тушаалаар батлсан. Тус журмын дагуу Даргын зөвлөл 2017 онд нийт 7 удаа хуралдаж, 17 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл тухай бүр зохих ёсоор баталгаажиж байгаа бөгөөд байгууллагын албан хаагчид Даргын зөвлөлийн хуралд оролцох боломжийг нээлттэй болгосон. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 7.3.66. Тогтоол шийдвэрийн биелэлт, гүйцэтгэл, үр дүнг тайлагнах журмын төслийг боловсруулах</p>	<ul style="list-style-type: none"> - Журмын төслийг боловсруулах; - Журмын төсөлд албан хаагчдаас санал авах; - Газрын даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, газрын даргын тушаалаар батлах, V сард; 	<p>Байгууллагын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг тайлагнах ажлын зохион байгуулалт</p>	3Х3Х	<p>Журмын төслийг боловсруулах ажил хийгдээгүй. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу хугацаанд нь тайлагнаж байна. 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хуралдсан Даргын зөвлөлийн хуралд 2017 оны жилийн эцсийн байгууллагын тайлан мэдээг нэгтгэн дээд шатны байгууллагад хүргүүлэх хугацаа, хуваарийг хэлэлцүүлэн, хурлын тэмдэглэлээр хэлтсийн дарга нарт үүрэг чиглэл</p>

	<ul style="list-style-type: none"> - Хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, жилдээ. 	сайжирна.		өгсөн. (“Хэрэгжилт хангалтгүй” – 30%)
<p>Арга хэмжээ 7.4.67. Байгууллагын “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө”-г боловсруулах, батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Ажлын хэсэг байгуулах; - Байгууллагын гамшгаас хамгаалах бэлэн байдлын нөхцөл байдалд үнэлгээ, судалгаа хийх; - “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө”-ний төслийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нийцүүлэн боловсруулах; - Төслийг газрын даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх; - Төслийг хуульд заасны дагуу холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулах, батлуулах, VIII сард; - Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах, жилдээ; 	Гамшгаас хамгаалах бэлэн байдал хангагдаж, менежмент сайжирна.	ЗХЗХ, Ажлын хэсэг	Байгууллагын “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө”-г боловсруулах ажил хийгдээгүй. (“Хэрэгжээгүй” - 0)
<p>Арга хэмжээ 7.5.68. Байгууллагын архивын зааврын төслийг боловсруулах, батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Зааврын төслийг хууль тогтоомж, эрх зүйн актад нийцүүлэн боловсруулах; - Зааврын төсөлд албан хаагчдаас санал авах; - Зааврыг газрын даргын Зөвлөлөөр хэлэлцүүлэн, газрын даргын тушаалаар батлуулах; - I/20-ны дотор. 	Байгууллагын баримт бичгийн эмх цэгц, хадгаламжийн нэгжийн бүрдэл, ашиглалт, хадгалалт сайжирна.	ЗХЗХ, Ажлын хэсэг	Байгууллагын архивын зааврын төсөл боловсруулагдаагүй байна. “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн заавар”-ын төслийг боловсруулж, 2017 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр газрын нийт албан хаагчид танилцуулан саналыг тусган Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/12 дугаар тушаалаар баталсан. Тус зааврыг байгууллагын цахим сүлжээнд байрлуулан албан хаагчдад таниулан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. (“Хэрэгжилт хангалтгүй” – 30%)
<p>Арга хэмжээ 7.6.69. Нууцын журмын төслийг боловсруулах, батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Журмын төслийг хууль тогтоомж, эрх зүйн актад нийцүүлэн боловсруулах; - Журмын төсөлд Тагнуулын байгууллагаас санал авах; - Төслийг газрын даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх; - Газрын даргын 	Байгууллагын нууцын асуудал хууль эрх зүйн хүрээнд явагдах боломж бүрдэнэ.	ЗХЗХ	Төрийн болон албаны нууцын тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 09 дүгээр сараас мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор журмын төслийг боловсруулах ажил хүлээгдэж байгаад 2018 онд боловсруулан батлуулахаар хойшлуулсан. (“Хэрэгжээгүй” – 0)

	<ul style="list-style-type: none"> тушаалаар батлуулах; - Албан хаагчдад танилцуулан, ил тод мэдээлэх; - II/20-ны дотор. 			
<p>Арга хэмжээ 7.7.70. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журмын төслийг боловсруулах, батлах</p>	<ul style="list-style-type: none"> - Журмын төслийг хууль тогтоомж, эрх зүйн актад нийцүүлэн боловсруулах; - Журмын төсөлд албан хаагчдаас санал авах; - Журмыг газрын даргын Зөвлөлөөр хэлэлцүүлэх; - Газрын даргын тушаалаар батлах; - Албан хаагчдад танилцуулан, ил тод мэдээлэх; - IV/20-ны дотор. 	<p>Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, ил тод байдлыг хангах эрх зүйн зохицуулалт тодорхой болно.</p>	<p>ЗХЗХ, Ажлын хэсэг</p>	<p>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”-ын төслийг боловсруулж, газрын дотоод сүлжээний www.able.mn -нд байршуулан нийт албан хаагчдаас санал авч тусган Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанд танилцуулан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/169 дугаар тушаалаар баталсан. Журмыг байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж эхэлсэн.</p> <p>(“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 7.8.71. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгах санал боловсруулах</p>	<ul style="list-style-type: none"> - Ажлын хэсэг байгуулах; - Хэлтсүүдээс санал авч, нэгтгэн боловсруулах; - Саналыг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэх; - Саналын төслийг удирдлагад танилцуулж, Сангийн яаманд хүргүүлэх; - II-III сард. 	<p>МУ-ын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тодорхой асуудал тусгагдсан байна.</p>	<p>ЗХЗХ, Ажлын хэсэг</p>	<p>Сангийн яамны 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 5-2/491 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн дагуу Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тус байгууллагын чиг үүрэгтэй холбоотой асуудлыг тусгах санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг газрын даргын 2017 оны А/26 дугаар тушаалаар байгуулан ажиллуулж, саналыг нэгтгэн боловсруулав. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналыг 2017 оны А-1/356 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоолоор Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлагдсан бөгөөд тус байгууллагын хэрэгжүүлэх 4 арга хэмжээ тусгагдсан байна.</p> <p>(“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 7.9.72. ТӨБЗГ-ын дотоод аудитын үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөг боловсруулах, батлах</p>	<ul style="list-style-type: none"> - Төлөвлөгөөний төслийг боловсруулах; - Газрын даргын тушаалаар батлах; - Албан хаагчдад танилцуулан, ил тод мэдээлэх; - Дотоод аудитын үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах; 	<p>Байгууллагын үйл ажиллагаа, эрсдлийн удирдлага сайжирч, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлнэ.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны А/55 дугаар тушаалаар Байгууллагын дотоод аудитын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэв. 2017 онд дараах чиглэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт, аудит хийж, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох албан хаагчдад хүргүүлсэн байна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Түрээслэгчийг сонгон шалгаруулах, түрээсийн гэрээний хэрэгжилтэд; 2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хүний нөөцийн үйл ажиллагаанд; 3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг

	- IV сард.			хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, архив, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд; 4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн үйл ажиллагаанд; 5. Засгийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай тогтоолын хэрэгжилт. ("Бүрэн хэрэгжсэн" – 100%)
Арга хэмжээ 7.10.73. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	- Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулах; - Албан хаагчдаас санал авч, төлөвлөгөөний төсөлд тусгах; - Төлөвлөгөөг газрын даргын тушаалаар батлах, II сард; - Цахим хуудсанд байршуулж, олон нийтэд ил тод мэдээлэх; - Хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, жилдээ.	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна.	ЗХЗХ	Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг тусад нь боловсруулж батлуулаагүй. Байгууллага, хэлтсийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон хариуцсан албан хаагчийн жил, сар бүрийн ажлын төлөвлөгөөнд холбогдох ажил, арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-г хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан төлөвлөгөөнд тус байгууллагын чиг үүрэгтэй холбоотойгоор тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалтаар ханган ажиллав. Эдгээр баримт бичигт төлөвлөгдсөн ажлыг 2018 онд зохион байгуулахад шаардлагатай хөрөнгийн тооцоог холбогдох хэлтэс, албан тушаалтнаар хийлгэж, байгууллагын төсөвт суулгах талаар зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж, нийт 157.8 сая төгрөгийг шийдвэрлүүлээд байна. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан хугацаа, хуваарийн дагуу дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор хэрэгжилтийг тайлагнана. Холбогдох хэлтсүүдээс хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргуулж, ЗХЗХ-т нэгтгэхээр зохион байгуулалтын арга хэмжээ авсан. Байгууллагын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг байгууллагын цахим хуудас www.pcsp.gov.mn , байгууллагын дотоод сүлжээ www.able.mn цахим системд тус тус байршуулж, олон нийтэд болон албан хаагчдад сурталчлан таниулсан. ("Хэрэгжих шатанд" – 70 %)
Арга хэмжээ 7.11.74. Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд хийгдэх мэдүүлгийн	- Мэдүүлэг гаргагч албан хаагчдад мэдүүлэг мэдүүлэх хуулийн хугацааг сануулах, хууль	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан	ЗХЗХ	Тайлант хугацаанд мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2016 оны тайлан мэдээг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд буюу 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А-1/380 дугаар албан бичгээр АТГ-т хүргүүлэв. Тайланд нийт 79 салбар байгууллагын мэдүүлгийн бүрдүүлэлтийн статистик мэдээ хамрагдсан. "Аж үйлдвэрийн цогцолбор" ХХК, "Монгол тамга"

<p>бүрдүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах</p>	<p>таниулах; - Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг цахимаар мэдүүлэх боломж нөхцлөөр хангах; - Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг гаргуулан холбогдох журмын дагуу бүртгэлүүдийг хөтлөн баталгааны хуудсаар хүлээж авах, - Мэдүүлэг, мэдэгдлийг бүртгэн хүлээж авах; - Мэдүүлгийн бүрдүүлэлтийн тайлан, мэдээ, ЭБАТ-ын тайланг гаргаж, АТГ-т хүргүүлэх, III/01-ний дотор; - Мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг жилийн турш зохион байгуулах.</p>	<p>байна. Зөрчил доголдол гаргаагүй байх.</p>	<p>ТӨҮГ, ЦЕГ-ын харьяа “Цагаан шонхор” ТӨҮГ, Булган аймгийн Хангал суман дахь “Спорт бэлтгэлийн төв” ТӨҮГ гэсэн 4 байгууллагын хувьд зөвхөн дарга нь (“Цагаан шонхор” ТӨҮГ-ын захирал ЦЕГ-т мэдүүлсэн) ХАСХОМ мэдүүлсэн.</p> <p>Мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2016 оны тайлан, мэдээний нэгдсэн дүнгээс (харьяа хуулийн этгээдийн мэдээ орсон дүн):</p> <ul style="list-style-type: none"> ✓ 79 байгууллагын дүнгээр 984 мэдүүлэг гаргагч ХАСХОМ шинэчлэн мэдүүлсэн; ✓ Хөрөнгө орлогын ИХӨ-ийг 22 мэдүүлэг гаргагч мэдүүлсэн. ✓ Давхардсан тоогоор, албан тушаалд нэр дэвшсэн 629 нэр дэвшигчийн ХАСУМ-ийг хүлээн авч, АТГ-аар хянуулсан. ✓ 1238 АСМ-ийг хүлээн авч бүртгэсэн. Үүнээс 1 нь ашиг сонирхлын зөрчил үүссэн тухайгаа мэдэгдсэн. <p>Мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2017 оны явцын мэдээг 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар танилцуулбал (зөвхөн ТӨБЗГ-ын мэдээ):</p> <ul style="list-style-type: none"> ✓ Нийт 141 нэр дэвшигч (ТӨБЗГ-т шинээр 20, захиралд 11, ТУЗ-ын гишүүнд 110 [28 ТӨБЗГ+23 яам, бусад+59 хараат бус])-ийн ХАСУМ-ийг бүртгэлээр хүлээн авч, АТГ-т хүргүүлэн хянуулав. ✓ ТӨБЗГ-т шинээр албан тушаалд томилогдсон нийт 18 албан хаагчийн, тус байгууллагын харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн захирлаар томилогдсон 9 албан хаагчийн ХАСХОМ-ийг гаргуулж, тус тус хүлээн авав. ✓ Хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлсэн 6 (3 ТӨБЗГ+3 захирал) тохиолдол гарсан байна. ✓ Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах, хяналт, шалгалт хийх болон бусад шалтгаанаар албан хаагчдаас гаргасан 316+ АСМ бүртгэн авч, АТГ-ын цахим системд оруулах ажлыг хийж байна. 12 дугаар сард багтаан системд шивж оруулах ажлыг дуусгахаар ажиллаж байна. <p>2017 онд шинээр байгуулагдсан “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨҮГ, “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Ховд дулааны цахилгаан станц” ТӨХК-ийг мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд нэмж бүртгүүлэх талаар ТӨБЗГ-ын 2017 оны А-1/1204, А-1/2744 дугаар албан бичгээр АТГ-т хүсэлт хүргүүлж, эрх нээлгэн авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх боломж нөхцөл, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллав.</p>
--	--	---	---

				<p>“Монголын төмөр зам” ТӨХК-иас ирүүлсэн хүсэлтийг судалж үзэн авлигын эсрэг хууль тогтоомж, Компанийн тухай хуульд нийцүүлсэн зөвлөмж, саналыг боловсруулан 2017 оны А-1/3148 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.</p> <p>Мэдүүлэг гаргагч албан хаагчдад мэдүүлэг, мэдэгдэл мэдүүлэхтэй холбоотой заавар, зөвлөгөө, хуулийн хугацаа сануулах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэн ажиллав. Тайлант хугацаанд, давхардсан тоогоор нийт 711+ мэдүүлэг гаргагч албан тушаалтанд ХАСХОМ, ИХӨ, ХАСУМ, АСМ гаргах асуудлаар, 76 салбар ЭБАТ-д биечлэн харьцаж, хуулийн хугацаанд мэдүүлгээ хүлээлгэж өгөх талаар хуулийн хугацаа сануулан, ЭБАТ-ын үйл ажиллагааны талаар мэдээлэл, арга зүй, зөвлөгөө, дэмжлэгээр хангаж ажилласан дүнтэй байна.</p> <p>Эдгээр мэдүүлэг, мэдэгдэл тус бүр дээр ЭБАТ-ын бүртгэлийг хөтөлж, цахим системд бүртгэлийн мэдээллийг оруулж авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 7.12.75. Дээд шатны байгууллагаас батлан гаргасан холбогдох бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, тайлагнан мэдээлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Тогтоол, шийдвэрийн хяналтад авсан заалтын судалгааг нарийвчлан гаргах; - Шинээр ирсэн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангах; - Хэлтсүүдээс холбогдох шийдвэрийн хэрэгжилтийн тайлан, мэдээллийг авч, нэгтгэн боловсруулах; - Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан журмыг хэрэгжүүлж, тогтоосон хугацаа, хуваарийн дагуу дээд шатны байгууллагад тайлагнан мэдээлж 	<p>Байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай холбогдох бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл дээд шатны байгууллага, иргэд, олон нийтэд ил тод мэдээлэгдэнэ.</p>	<p>ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА</p>	<p>Тайлант хугацаанд дараахь бодлого, шийдвэрийн биелэлтийн тайлан, мэдээг хагас жилийн дүнгээр гаргаж ЗГХЭГ, Сангийн яаманд хүргүүлж, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хэрэгжүүлж ажилласан:</p> <p>1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2017 оны хагас жилийн дүнгээр нэгтгэн гаргаж, ХШҮ-ний тайлан, Даргын зөвлөлийн хурлын 05 дугаар тэмдэглэлийн хамтаар ЗГХЭГ-т А-2/2022 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2017 оны эхний хагас жилийн байдлаар ТӨБЗГ-т хэрэгжүүлэх нийт 22 арга хэмжээний хэрэгжилт 62.1 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн.</p> <p>2. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн эхний хагас жилийн биелэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтээр тайлагнасан. Энэхүү үндсэн чиглэлд тус байгууллагын эрхлэх асуудалтай холбоотой “Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого”-ын хүрээнд хамаарах 2 зорилт, арга хэмжээ тусгагдсан бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглсэн нийт 10 үйл ажиллагаа (арга хэмжээ) төлөвлөгдсөн. Энэхүү Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн ерөнхий дундаж үнэлгээ – “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу</p>

	<p>ажиллах;</p> <ul style="list-style-type: none"> - Цахим систем, дотоод сүлжээгээр олон нийт, албан хаагчдад мэдээлэх, тухай бүр; - Жилдээ. 			<p>70.0 %-ийн дүнтэй гарсан. Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг, түүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн тэмдэглэлийн хамтаар ТӨБЗГ-ын 2017 оны А-1/1619 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>3. 2017 оны эхний хагас жилийн дүнгээр тус байгууллагын бүртгэл-хяналтад авсан, хэрэгжилтийг ЗГХЭГ-т тайлагнах шаардлага бүхий хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг, ХШҮ-ний тайлан, Даргын зөвлөлийн хурлын 04 дүгээр тэмдэглэлийн хамтаар ЗГХЭГ-т А-2/1693 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Нийт 6 төрлийн 51 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 68 заалтын хэрэгжилт өөрийн үнэлгээгээр 76.2 хувьтай гарсан бөгөөд хэрэгжилтийн явц удаашралтай байгаа буюу 30 хувиас доош үнэлгээтэй 6, хэрэгжээгүй 3 заалт байсныг сүүлийн хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллах талаар Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр холбогдох хэлтэст үүрэг чиглэл өгсөн.</p> <p>Нийт 13 шийдвэрийн 16 заалтыг ТӨБЗГ-ын нэр дээр хяналтад байлгаж, дээд шатанд хэрэгжилтийг тайлагнах бүртгэл-хяналтаас хасуулах саналыг боловсруулж уг тайланд тусгасан.</p> <p>Дээрх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайлан мэдээ гарах хугацаа болоогүй, хэрэгжилтийг тайлагнах бэлтгэл, зохион байгуулалтын арга хэмжээ аваад байна.</p> <p>2017 оны 7 дугаар сараас эхлэн сар бүрийн байгууллагын хийсэн ажлын гол мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ХШҮДАГ-т хүргүүлэн, мөн Засгийн газрын “Төрийн мэдээллийн сүлжээ” - http://new.unelgee.gov.mn цахим системд сар бүр оруулан Засгийн газрын хяналтад хамруулж байгаа. (“Хэрэгжих шатанд” – 70 %)</p>
<p>Арга хэмжээ 7.13.76. Газрын хуралдаан, газрын даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг тооцох</p>	<ul style="list-style-type: none"> - Ажил хэрэгч шийдвэрүүд, хурлын тэмдэглэлээр өгсөн үүргийг хяналтад авах; - Хэлтсүүдээс биелэлт, тайлан, мэдээллийг авч, хэрэгжилтийг тооцох, Газрын хуралдаан болон газрын даргын Зөвлөлд тус тус 	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудлаарх хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдана.</p>	<p>ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаан 2017 онд (12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар) нийт 27 удаа зохион байгуулагдаж давхардсан тоогоор 665 асуудал хэлэлцэж, 639 тогтоол, 19 тэмдэглэл албажин, цаг үеийн шинжтэй 6 мэдээлэл, дахин хэлэлцэх 21 асуудал албажаагүй байна. 658 тогтоол, тэмдэглэлийг агуулгаар нь ангилан харуулбал:</p> <ul style="list-style-type: none"> - Эрх зүйн акттай холбоотой 31; - Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, дүрэм, зохион байгуулалтын бүтцийн талаар 14; - Төрийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн талаар 143;

	<ul style="list-style-type: none"> танилцуулах; - Хэрэгжилтийн явцыг олон нийтэд байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээлэх; - Улиралд. 			<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагыг томилох, чөлөөлөх талаар 19; - Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх талаар 21; - Хөрөнгө оруулалт, эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөний талаар 385; - Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний талаар 42. <p>Албажуулсан тогтоол, тэмдэглэлийг байгууллагын цахим хуудсанд тухай бүр байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Газрын хуралдааны шийдвэрийн биелэлтийг 2017 оны 3 дугаар улирлын байдлаар гарган Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 7.14.77. Хууль, шүүхийн байгууллагад үүссэн хэрэг, маргаанд байгууллагыг төлөөлж нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцох, тайлбар мэдүүлэг, нотлох баримт гаргаж өгөх</p>	<ul style="list-style-type: none"> - Тухайн хэрэг, маргааны асуудлаар холбогдох албан хаагчидтай хамтран ажиллах; - Хуулийн хүрээнд хэрэг, маргааныг шийдвэрлүүлсэн байх; - Шийдвэрлэлтийн байдлын талаар удирдлагад танилцуулах; - Жилдээ. 	Хэрэг, маргааны шийдвэрлэлт ахисан байна.	ЗХЗХ	Тайлант жилд, ТӨБЗГ нь итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан нийт 30 шүүх, арбитрын хэрэг, маргаанд нэхэмжлэгч болон хариуцагчаар оролцсон байна. Тэдгээрээс 6 хэрэг, маргаанд нэхэмжлэгчээр, 24 хэрэг, маргаанд хариуцагчаар оролцсон. Эдгээр хэрэг маргааныг шүүхийн харьяаллаар ангилбал, Эрүүгийн хэргийн шүүхийн маргаан 1, Иргэний хэргийн шүүхийн маргаан 13, Захиргааны хэргийн шүүхийн маргаан 15, Арбитрын харьяаллын маргаан 1 байна. Шүүх, арбитрт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцсон хэрэг, маргааны шийдвэрлэлтийн байдал: Нийт 29 хэрэг, маргаанаас 7 хэрэг, маргаан шүүхийн шатанд, 3 хэрэг, маргаан түдгэлзсэн, 13 хэрэг маргаан нь ТӨБЗГ-ын талд, 7 хэрэг, маргаан нь эсрэг талд шийдвэрлэгдсэн байна. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)
<p>Арга хэмжээ 7.15.78. Албан бичиг, эрх зүйн болон захиргааны акт, хурлаар хэлэлцүүлэх асуудлын төслийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянах</p>	<ul style="list-style-type: none"> - Төслийг хянаж, хууль зүйд нийцүүлэх арга хэмжээ авах; - Хянасан бичиг, эрх зүйн актын бүртгэл хөтлөх; - Өдөр тутамд. 	Хуульд нийцсэн албан бичиг, эрх зүйн акт албажсан байх	ЗХЗХ	Тайлант хугацаанд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төсөл 665, тушаал, албан бичиг, тендерийн баримт бичиг, урилга, мэдэгдлийн төсөл зэрэг 993 баримт материалын төслийг хянаж, хууль, эрх зүйд нийцүүлэн боловсруулж, албажуулахад дэмжлэг үзүүлсэн. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)
<p>Арга хэмжээ 7.16.79. Орон нутгийн нэгжийн мэргэжилтнүүдэд зориулсан нэгдсэн сургалт-семинар зохион байгуулж, арга зүйгээр хангах</p>	<ul style="list-style-type: none"> - Сургалт-семинарын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, батлуулах; - 21 аймгийн Орон нутгийн өмчийн газар, нийслэл, дүүргийн өмчийн харилцааны болон худалдан авах ажиллагааны нэгжийн удирдлага, албан хаагчдыг хамруулах; 	Орон нутгийн өмчийн болон худалдан авах ажиллагааны нэгжийн чадавхи сайжирна.	ЗХЗХ, ТӨБХХ, МТА	2017 оны 03 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд 21 аймгийн Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, 9 дүүргийн худалдан авах ажиллагааны албадын албан хаагчдыг хамруулсан сургалт, хэлэлцүүлгийг, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Авлигатай тэмцэх газар, “Компанийн засаглалын үндэсний зөвлөл” ТББ-тай хамтран зохион байгуулсан. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)

	<ul style="list-style-type: none"> - Тайлан хүлээн авч, баталгаажуулах; - I улиралд. 			
<p>Арга хэмжээ 7.17.80. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах</p>	<ul style="list-style-type: none"> - Санал боловсруулж, удирдлагын түвшинд танилцуулах; - Олон улсын байгууллага, холбогдох бусад байгууллагатай холбогдох; - III/25-ны дотор. 	<p>Гадаад хамтын ажиллагаа өргөжинө. Гадаадын ижил төстэй байгууллагын туршлагыг судлах, байгууллагын чадавхийг сайжруулах боломж бүрдэнэ.</p>	<p>ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА</p>	<p>Дэлхийн банкны “Монгол, Вьетнам улсын худалдан авах ажиллагааны статистикийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд “Цахим худалдан авах ажиллагааны системийн хэрэглэгчийн чадавхийг сайжруулах сургалт”-ыг улсын хэмжээнд үе шаттайгаар зохион байгуулж, нийт 1551 хэрэглэгчийг хамруулсан байна. Энэ арга хэмжээний хүрээнд 2017 оны 02 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд Вьетнам улсын Худалдан авах ажиллагааны агентлагийн албан хаагчид Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим худалдан авах ажиллагааны туршлагаас судлах уулзалт, сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкттай хамтран ажиллаж, худалдан авах ажиллагааны болон байгууллагын албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын сургалтад давхардсан тоогоор нийт 41 мэргэжилтнийг хамруулж, эдгээр донор байгууллагын санхүүжилттэй хэрэгжиж байгаа зарим худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т зохион байгуулах зэргээр хамтран ажиллаж байна.</p> <p>(“Хэрэгжилт хангалтгүй” – 30%)</p>
<p>ХӨТӨЛБӨР ҮИИ “Хүний нөөцийн чадавхийг сайжруулж, хэлтэс, албан хаагчдын гүйцэтгэл, үр дүнг дээшлүүлэх, сахилга, хариуцлагыг өндөржүүлэх” хөтөлбөрийн хүрээнд:</p>				
<p>Арга хэмжээ 8.1.81. Албан хаагчдын нийгмийн баталгаа, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний төсөл боловсруулж, батлах</p>	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийг боловсруулахад шаардлагатай цогц судалгаа хийх; - Судалгаанд үндэслэн нийгмийн баталгаа, хангамж, сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох; - Хэрэгжүүлэх арга хэмжээ, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон хөтөлбөрийн төслийг боловсруулах; - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах; - Хөтөлбөр, 	<p>Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгаа, сургалт, хөгжлийн бодлого, төлөвлөлт тодорхой болно.</p>	<p>ЗХЗХ, Ажлын хэсэг</p>	<p>Албан хаагчид хуулиар тогтоосон тусламж, тэтгэмж, дэмжлэг, нөхөн олговор олгох, нийгмийн баталгааг хангах, үр бүтээл, тогтвор суурьшилтай ажиллах, албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”, албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадварыг дээшлүүлэх, байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийн төслийг тус тус боловсруулсан. Уг төслийг газрын дотоод сүлжээний www.able.mn цахим системд байршуулан нийт албан хаагчдаас санал авсан. Мөн 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдөр албан хаагчдын дунд төсөлд санал авах хэлэлцүүлэг зохион байгуулсан. Албан хаагчдын саналыг тусган дээрх 2 хөтөлбөрийг эцэслэн боловсруулж, 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох саналыг тусгаж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны А/107 дугаар тушаалаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан</p>

	<p>төлөвлөгөөний төсөлд албан хаагчдаас санал авах;</p> <ul style="list-style-type: none"> - Хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, газрын даргын тушаалаар батлах; - Албан хаагчдад танилцуулан, ил тод мэдээлэх; - III/20-ны дотор. 			<p>хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийг, А/108 дугаар тушаалаар "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг тус тус баталсан. Эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллав.</p> <p>("Бүрэн хэрэгжсэн" – 100%)</p>
<p>Арга хэмжээ 8.2.82. Албан хаагчдын нийгмийн баталгаа, сургалтын үйл явцыг зохицуулах журмын төсөл боловсруулж, батлах</p>	<ul style="list-style-type: none"> - Журмын төслийг боловсруулж, албан хаагчдаас санал авах; - Журмын төслийг нэгтгэн боловсруулж, газрын даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх; - Газрын даргын тушаалаар батлах; - Мөрдүүлэх арга хэмжээ авч ажиллах; - Албан хаагчдад танилцуулан, ил тод мэдээлэх; - Y/20-ны дотор. 	<p>Албан хаагчдын нийгмийн баталгаа, сургалтын үйл ажиллагаанд мөрдөх хэм хэмжээ тодорхой болж, дотоод зохион байгуулалт сайжирна.</p>	<p>ЗХЗХ, Ажлын хэсэг</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид хуулиар олгогдсон тэтгэмж, тусламж, нөхөн олговор олгох, ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлэх зорилгоор "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид тусламж, тэтгэмж, нөхөн олговор олгох журам"-ын төслийг зохих судалгаа, холбогдох хууль тогтоомжийг үндэслэн боловсруулсан. Журмын төслийг газрын дотоод сүлжээний www.able.mn цахим системд байршуулан нийт албан хаагчдаас санал авч, мөн 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдөр албан хаагчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан. Уг хэлэлцүүлгийн үеэр гарсан болон дотоод сүлжээгээр ирүүлсэн саналыг тусган төслийг эцэслэн боловсруулж, 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/106 дугаар тушаалаар "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид тусламж, тэтгэмж, нөхөн олговор олгох журам"-ыг баталсан. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын А/105 дугаар тушаалаар "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шагналын журам"-ыг батлан мөрдүүлж байна. ("Бүрэн хэрэгжсэн" – 100%)</p>
<p>Арга хэмжээ 8.3.83. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн ёс зүйн дүрмийг боловсруулан батлах</p>	<ul style="list-style-type: none"> - Ёс зүйн дүрмийн төслийг боловсруулан албан хаагчдын саналыг тусгах; - Дүрмийг газрын даргын тушаалаар батлах; - Ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх ажлыг 	<p>Албан хаагчдын Ёс зүйн байдалд гарсан аливаа асуудлыг шийдвэрлэх боломж бий болно.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн ёс зүйн дүрмийн төслийг боловсруулан, 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр газрын дотоод сүлжээнд байршуулан, нийт албан хаагчдаас санал авсан. Саналыг нэгтгэн боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/15 дугаар тушаалаар "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг баталсан. Ёс зүйн дүрмийг газрын дотоод сүлжээ, цахим хуудаст байршуулан албан хаагчдад танилцуулан ил тод мэдээлэн сурталчилсан.</p>

	<p>зохион байгуулах;</p> <ul style="list-style-type: none"> - I сард. 			<p>Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, ёс зүйн хороо, албан хаагчийн ёс зүй, хувцаслалтын талаар Төрийн албаны зөвлөлийн ахлах референт н.Зоригтбаатар 2017 оны 02 дугаар сарын 21-ний өдөр нийт албан хаагчдад зориулан лекц уншсан. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 8.4.84. Хэлтэс, албан хаагчид хийх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж, ажлаа тайлагнан мэдээлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хэлтсийн ажлыг улирал, жилээр, албан хаагч сараар төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг хангах; - Газрын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөтэй уялдуулах; - Хэлтсийн ажлын гүйцэтгэл, үр дүнг холбогдох журамд заасан хугацаанд тайлагнан мэдээлэх; - Байгууллагын цахим хуудас, дотоод сүлжээгээр дамжуулан ажлаа сурталчлан мэдээлэх, тухай бүр. 	<p>Хэлтэс, албан хаагчийн үйл ажиллагааны тайлагналт, үр дүн сайжирч, мэдээллийн ил тод байдал хангагдана.</p>	<p>ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА</p>	<p>ТӨБЗГ-ын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хэлтэс бүр жил, улирлын төлөвлөгөө, албан хаагч бүр сарын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна. Газрын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөтэй уялдуулан ажиллахад анхааран ажиллаж, нийт албан хаагчдад газрын төлөвлөгөөг дотоод сүлжээгээр дамжуулан хүргэж, танилцуулсан.</p> <p>Албан хаагчийн гүйцэтгэлийн үр дүнг байгууллагын үйл ажиллагааны үр дүнтэй холбож, гүйцэтгэл, тайлагналтыг сайжруулахад чиглэсэн сургалт, семинарыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газартай хамтран 12 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулав.</p> <p>Засгийн газрын өгсөн чиглэлийн дагуу 07 дугаар сараас хойш байгууллагын сарын ажлын тайлан мэдээллийг нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байгаа бөгөөд Төрийн мэдээллийн сүлжээ http://loginnew.unelgee.gov.mn цахим системд оруулж, Засгийн газрын хяналтад авахуулах арга хэмжээ авч ажиллав.</p> <p>(“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 8.5.85. Нийт албан хаагчидтай 2017 оны үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ байгуулж, гүйцэтгэл, үр дүнг дүгнэх ажлыг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор баталсан заавар, 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан журмыг баримтлах арга хэмжээ авах; - Ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн албан хаагчидтай Үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ байгуулах; - Шууд удирдах нэгжийн дарга тухайн албан хаагчийн үр дүнгийн гэрээг батлах, I сард; - Албан хаагчдын үр 	<p>Албан хаагчдын хариуцлагын тогтолцоо сайжирч, гүйцэтгэлийн үр дүнг хянах боломжтой болно. Байгууллагын стратегийн зорилт хангагдана.</p>	<p>ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА</p>	<p>2017 онд төрийн захиргааны 75 албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан. Төрийн үйлчилгээний албан хаагчтай “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Хөдөлмөрийн гэрээний загварыг баримтлан 2 албан хаагчийн хөдөлмөрийн гэрээний хугацааг сунгаж, 7 албан хаагчтай шинээр хөдөлмөрийн гэрээ байгуулсан.</p> <p>Үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж, дүгнэсэн. Албан хаагчидтай байгуулсан үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэж, хариуцсан ажлын байрны чиг үүрэг, албан ажлаа үр дүнтэй биелүүлсэн албан хаагчид ТӨБЗГ-ын даргын 2017 оны А/192 дугаар тушаалаар үр дүнгийн гэрээний урамшуулал олгов. 2018 оны үр дүнгийн гэрээний урамшуулалд нийт 75 албан хаагч хамрагдаж, нийт 21.9 сая төгрөг зарцуулсан байна. Үр дүнгийн гэрээний биелэлтээр “С” буюу “Хангалттай”, “D” буюу “Дутагдалтай” дүгнэгдсэн 3 албан хаагчид ажлын үр дүнг сайжруулах тухай үүрэг чиглэл өгч, ажил үүргээ гүйцэтгэхэд нь мэргэшил, арга зүйн дэмжлэг, зөвлөгөө өгч, мэдлэг чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн 2018</p>

	<p>дүнгийн гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулах, YI, XII сард;</p> <ul style="list-style-type: none"> - Үр дүнгийн гэрээг дүгнэж, түүний мөрөөр авах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэх. 			<p>оны зорилтот сургалтад хамруулахаар шийдвэрлэсэн.</p> <p>(“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 8.6.86. Нийт албан хаагчдыг соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, байгууллагын соёлыг хэвшүүлэх арга хэмжээ авах</p>	<ul style="list-style-type: none"> - Ёс зүй, харилцааны болон байгууллагын соёлтой холбоотой сэдэв, агуулга бүхий сургалт зохион байгуулах; - Мэргэжлийн сургалтын байгууллага, лекторуудтай холбогдож, хамтран ажиллах; - Сургалтын товыг гаргаж, нийт албан хаагчдыг хамруулах; - Зохион байгуулалтад хэлтэс бүрийн оролцоог хангах; - Сар бүр. 	<p>Байгууллагын соёл төлөвшинө. Албан хаагчдын чадавхи дээшилнэ.</p>	<p>ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА</p>	<p>Газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/107 дугаар тушаалаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав.</p> <p>Албан хаагчдын 2017 оны сургалтын төлөвлөгөөний төслийг боловсруулан, 09 дүгээр сарын 05-ны өдөр батлуулж, дотоод сүлжээний зар мэдээ хэсэгт байршуулан нийт албан хаагчдад мэдээлсэн. Сургалтын төлөвлөгөөний дагуу ЗХЗХ, ТӨБХХ-ээс албан хаагчдыг соён гэгээрүүлэх, мэдлэг мэргэшлийг нь дээшлүүлэх сургалт зохион байгуулагдсан байна.</p> <p>Байгууллагын хэмжээнд 2017 онд нийт албан хаагчдыг хамруулсан 31 лекц, сургалт зохион байгуулагдаж, албан хаагчийн мэдлэг, чадавхийг бэхжүүлэхэд анхааран ажиллав:</p> <ul style="list-style-type: none"> - Худалдан авах ажиллагаатай холбоотой гадаадад туршлага судлах сургалт 5 удаа зохион байгуулагдаж, нэр бүхий 22 албан хаагч хамрагдсан; - Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах сургалт – 2 удаа; - Төрийн байгууллагын стратегийн удирдлага, манлайлал, төрийн албан хаагчийн ёс зүй, албан хэрэг хөтлөлтийн талаарх сургалт – 6 удаа; - Худалдан авах ажиллагаатай холбоотой дотоод сургалт – 1 удаа; - Хууль тогтоомжтой холбоотой – 4 удаа; - Мэргэшүүлэх – 2 удаа; - Дотоод аудитын – 3 удаа; - Эрүүл мэнд, зөв хооллолт, хөрөнгийн зах зээл, төсөл зэрэг бусад чиглэлээр 8 сургалт зохион байгуулагдсан байна. <p>Удирдлагын академийн төрийн захиргааны менежментээр мэргэшүүлэх гарагийн сургалтад 2 албан хаагч, гадаад улсад мэргэжил дээшлүүлэхээр 3 албан хаагч сургалтын гэрээ байгуулан суралцаж байна. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 8.7.87. Байгууллагын нийт албан хаагчдад холбогдох эрх зүйн</p>	<ul style="list-style-type: none"> - Шаардлагатай эрх зүйн туслалцаа үзүүлэх; - Тухай бүрд. 	<p>Албан хаагчид хариуцсан ажлын чиглэлээр</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн танилцуулах сургалтыг 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдөр, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн заалтыг ойлгож, хэрэгжүүлэх нь” сургалтыг 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдөр тус тус зохион</p>

туслалцаа үзүүлж, зөвлөгөө, мэдээллээр хангах, хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх		хууль, эрх зүйн зөрчилгүй ажилласан байна.		байгуулан газрын албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд арга хэмжээ авсан. Мөн байгууллагын албан хаагчдад эрх зүйн туслалцааг цаг тухай бүрт үзүүлэн ажилласан. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)
Арга хэмжээ 8.8.88. Нийт албан хаагчдад шинээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм, журмын талаар мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Ажилтнуудад шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгөх; - Дагаж мөрдөх дүрэм, журмыг танилцуулж, тайлбарлах; - Тухай бүрд. 	Албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг дээшилнэ.	ЗХЗХ	2017 оны 01 дүгээр сард “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн заавар”, 2017 оны 2 дугаар сард “Даргын зөвлөлийн ажиллах журам”, 2017 оны 06 дугаар сард “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шагналын журам”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид тусламж, тэтгэмж, нөхөн олговор олгох журам”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”-ыг байгууллагын дотоод сүлжээнд байршуулан албан хаагчдад танилцуулж ил тод мэдээлсэн. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)
ХӨТӨЛБӨР IX “Мэдээллийн технологийн ололтыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх замаар менежментийг сайжруулж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах” хөтөлбөрийн хүрээнд:				
Арга хэмжээ 9.1.89. Гадаадын улс орнуудын төрийн өмчийн бүртгэл, хяналтын болон худалдан авах ажиллагааны чиг хандлага, хууль, эрх зүй, цахим системийн талаар судалгаа хийж, сайн туршлагыг нэвтрүүлэх	<ul style="list-style-type: none"> - 1-5 орны худалдан авах ажиллагаа, системийн харьцуулсан судалгаа хийх; - 1-5 орны төрийн өмчийн бүртгэл, хяналтын үйл ажиллагаа, цахим системийн харьцуулсан судалгаа хийх; - Шинэ ололт, чиг хандлага, сайн туршлагыг судлах; - Нэвтрүүлж болох сайн туршлагын талаар дүгнэлт хийх; - Жилдээ. 	Хөгжлийн түвшинг харьцуулан тодорхойлсон байна. Дүгнэлт гаргасан байна. Төрийн өмчийн мэдээллийн системийг боловсронгуй болгох ажлын эхлэл тавигдсан байна.	МТА	Төрийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системийн цаашдын хөгжил, хөгжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулж удирдлагын түвшин танилцуулагдсан. Олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудад төслийн санхүүжилтийн хүсэлт бичиг явуулсан. Мэдээлэл, технологийн албаны дарга Н.Цэрэнсамбуу, мэргэжилтэн С.Халиун, В.Азжаргал нар 2017 оны 01 дүгээр сарын 16-21-ний өдрүүдэд Филиппин улсын Манила хотод зохион байгуулсан Дэлхийн банкны сургалтад хамрагдаж, тус улсын Худалдан авах ажиллагааны цахим системийн талаар судалсан ба статистик тоон мэдээллийг илүү боловсронгуй болгох талаар арга хэмжээг авч ажиллаж байна. Мэдээлэл, технологийн болон худалдан авах ажиллагааны нийт 8 албан хаагчийг 2017 оны 12 дүгээр сарын 4-8-ны өдрүүдэд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Филиппин улсын Манила хотод зохион байгуулагдсан Засгийн газрын худалдан авах ажиллагааг бэхжүүлэх сургалтанд хамуулж, олон улсын худалдан авах ажиллагааны туршлага судлах, шинэ мэдээлэл авах боломжоор хангаж ажиллав. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)
Арга хэмжээ 9.2.90. Цахим худалдан авах	- Цахим тендер шалгаруулалт зохион	Цахим худалдан авах	МТА	“Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ийн нэг дэд систем болох “Цахим тендер шалгаруулалтын систем”-ийн “Хялбаршуулсан

<p>ажиллагааны нэгдсэн системийн хэвийн үйл ажиллагааг хангаж, худалдан авах ажиллагааны үйл явцад мониторинг хийх</p>	<p>байгуулах боломж, нөхцлийг хангах;</p> <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн нэгжийг чадавхижуулах; - ААНБ-уудыг чадавхижуулах; - Мэдээллийн санд мониторинг хийж, зөвлөмж өгөх; - Тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж байгаа байдалд хяналт тавих; - Жилдээ. 	<p>ажиллагааны үр дүн олон нийтэд ил тод мэдээлэгдэнэ.</p>		<p>цахим тендер шалгаруулалт” хэсгийг ашиглалтад оруулж, анхны цахим тендерийн шалгаруулалтын урилгыг 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдөр зарлаж, нээлтийг 2017 оны 03 дугаар сарын 10-ны өдөр хийсэн. 11 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар https://tender.gov.mn системд “Хялбаршуулсан цахим тендер шалгаруулалт”-ын нийт 1974 урилга нийтлэгдсэн байна.</p> <p>Мөн “Цахим тендер шалгаруулалт”-ын системийг ашиглалтад оруулахтай холбоотой бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Үүнд: Цахим төлбөр тооцооны системийг холбох, тулгарсан асуудлыг тухай бүр шийдвэрлэх (Хаан банкнаас бусад банкны картыг унших, Голомт банкны и-меркантын систем)</p> <p>Цахим тендерийн баталгааны сервисийг бэлтгэж, ашиглалтад оруулах, туршилтын өгөгдөл бэлтгэх, заавар зөвлөмжөөр хангах (Монгол улсанд үйл ажиллагаа эрхэлдэг 11 банкны систем). Цахим тендерийн баталгааг Засгийн газрын бондын хэлбэрээр гаргах боломжийг бүрдүүлэх зорилгоор 2017 оны 10 дугаар 23-ны өдрийн А-1/2879 дугаар албан бичгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд хүргүүлээд байна. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 9.3.91. Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн дэд системүүдийг хэрэглээнд нэвтрүүлж, ашиглалтыг нэмэгдүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - “Цахим дэлгүүр”, “Цахим каталог”, “Цахим тайлан”, “Цахим гэрээ”-ний дэд системийг шинээр хэрэглээнд нэвтрүүлэх; - Дэд систем бүрийн ашиглалтыг нэмэгдүүлэх; - Худалдан авах ажиллагааны мэдээллийн санг боловсронгуй болгох; - Цахим худалдан авах ажиллагааны чадавхийг сайжруулах арга хэмжээ авах; - Жилдээ. 	<p>Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем улсын хэмжээнд хэрэгжинэ. Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийн бааз үүсч, худалдан авах ажиллагааны ил тод байдал хангагдана.</p>	<p>МТА</p>	<p>Систем дэх бараа, ажил, үйлчилгээний мэдээллийг баяжуулах зорилгоор захиалагч байгууллагуудад худалдан авах гэж буй бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл баазад бүртгэлгүй байгаа бол өөрсдөө оруулан ашиглах боломжийг нээж өгсөн. 2017 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар баазад нийт 12 036 бараа, ажил, үйлчилгээ бүртгэлтэй байна. 2018 онд Ерөнхий гэрээ байгуулж худалдан авах бараа, бүтээгдэхүүний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалт зохион байгуулагдах гэж байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн яамны харьяа байгууллагуудаас 2017 онд зарлагдсан эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтаар худалдан авсан барааны талаарх системд оруулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Ирэх онд Ерөнхий гэрээ байгуулах худалдан авалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тендер шалгаруулалтын өмнөх урьдчилсан уулзалтыг Эрүүл мэндийн салбарынхантай 11 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан.</p> <p>(“Хэрэгжих шатанд” – 70%)</p>
<p>Арга хэмжээ 9.4.92. Төрийн өмчийн мэдээллийн системийн</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчийн мэдээллийн системийн хэвийн үйл 	<p>Төрийн өмчийн бүртгэл, мэдээлэл</p>	<p>МТА</p>	<p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-тэй холбоотой асуудлаар нийт 29 байгууллагад зөвлөгөө, тусламж үзүүлсэн байна.</p>

хэвийн үйл ажиллагааг хангах	<p>ажиллагааг хангах;</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн хөрөнгийн бүртгэлийг цахим системд оруулах боломжоор хангах; - Жилдээ. 	сайжирна.		<p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-д зарим байгууллагын мэдээлэл дутуу байгааг бүрэн болгох үүднээс “Google Form”-ыг бэлдэж, байгууллагуудад хүргүүлсэн. 2017 оны 11 дүгээр сарын 24-ний байдлаар тус “Google Form”-оор дамжуулан 96 байгууллага өмчийн бүртгэлийн мэдээллээ ирүүлсэн байна.</p> <p>“Төрийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-ийн хэвийн үйл ажиллагааг хангах болон хэрэглэгчдэд зөвөлгөө өгөх ажлыг өдөр тутам явуулж байна. 21 аймгаас уг системтэй холбоотой гарч буй алдааны мэдээллийг хүлээн авч, шалтгааныг тогтоон системээс шалтгаалж гарсан алдааг тухай бүр засч, хэрэглэгчид мэдээлэн ажиллаж байна. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 9.5.93.</p> <p>Байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн шинэ ололтыг нэвтрүүлэх, албан хаагчдад мэдээллийн технологийн ашиглалтын чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын цахим мэдээллийн системийн дотоод болон гадаад сүлжээний хэвийн ажиллагааг хангах; - Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангахад чиглэсэн сувгийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах; - Төрийн байгууллагын цахим шуудан www.webmail.gov.mn -ийн хэвийн үйл ажиллагааг хангах, зааварчилгаа өгөх; - Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн боловсруулж, хөгжүүлэлт хийх; - Албан хаагчдыг мэдээллийн технологийн орчин үеийн ололтыг ашиглахад чиглэсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах; - Жилдээ. 	Байгууллагын мэдээллийн цахим системийн дотоод болон гадаад сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	МТА	<p>Энэ чиглэлээр:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын цахим мэдээллийн системийн дотоод болон гадаад сүлжээний хэвийн ажиллагааг хангаж ажилласан; 2. Төрийн байгууллагын цахим шуудан www.webmail.gov.mn -ийн хэвийн үйл ажиллагааг хангаж, нийт албан хаагчдад албан мэйл хаяг шинээр үүсгэж, зааварчилгаа өгч ажилласан; 3. Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн боловсруулж, хөгжүүлэлт хийсэн; 4. Байгууллагын нийт албан хаагчдад өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд шаардлагатай зөвлөмж туслалцааг хүргэсэн; 5. Цахилгааны хэлбэлзэл болон бусад шалтгаанаас үүдсэн сүлжээний тасалдлын асуудлын тухай бүр шуурхай шийдвэрлэн ажилласан; 6. Байгууллагын сүлжээний тог баригчийн хэвийн ажиллагааг хангаж ажиллав. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)
<p>Арга хэмжээ 9.6.94.</p> <p>Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган холбогдох хуульд заасан мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Шилэн дансны мэдээллийг www.shilendans.gov.mn цахим системд байршуулж, олон нийтэд мэдээлэх; - Шилэн дансны мэдээллийн самбарыг шинэчилж, 	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, байгууллагын төсөв, санхүүгийн мэдээллийн ил тод байдал хангагдана.	ЗХЗХ	<p>Байгууллагын батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийг хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, хөрөнгө оруулалт гэсэн мэдээллийг Шилэн дансны хууль, журмын дагуу http://shilendans.gov.mn цахим системд хугацаанд нь байршуулан, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан.</p> <p>(“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>

	<p>мэдээллээр тогтмол баяжуулах;</p> <ul style="list-style-type: none"> - Хуулийн хугацаанд, тухай бүрд. 			
<p>Арга хэмжээ 9.7.95. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах</p>	<ul style="list-style-type: none"> - Мэдээллийн самбар шинээр байршуулж, мэдээлэл түгээх; - Байгууллагын цахим хуудасны мэдээллийн чанарыг сайжруулах; - Өдөрлөг зохион байгуулж, үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлан таниулах; - Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх; - Жилдээ. 	<p>Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан байна.</p>	<p>ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА</p>	<p>Тайлант хугацаанд ТӨБЗГ-аас 2 удаа нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан. 2017 оны 04 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2017” өдөрлөгийг зохион байгуулж, түүнд нийт 80 гаруй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газар, 150 гаруй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид оролцож, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ иргэд, олон нийтэд танилцуулан сурталчилсан. Энэ өдөрлөгийн үеэр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, хуулийн ажилтнуудыг хамруулсан сургалт, ажил хэргийн семинар, хуулийн төслийн болон бодлогын хэлэлцүүлгийг төрөлжүүлэн зохион байгуулж, цаашид анхаарах асуудлыг тодорхойлох арга хэмжээ авав. 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас гаргасан хуваарийн дагуу Үндэсний хөгжлийн газартай хамтран Сүхбаатарын талбайд нээлттэй өдөр зохион байгуулж, үйл ажиллагаагаа сурталчилж, зарим үйлчилгээг иргэдэд нэг цэгээс шуурхай хүргэж үйлчилсэн.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагааны талаар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрхлэх асуудлын хүрээнд эхний 11 сарын байдлаар байгууллагын цахим хуудас, олон нийтийн цахим хуудсанд 102 мэдээ, мэдээлэл, 14 дуудлагын худалдааны зар байршуулсан. Олон нийтэд 106 мэдээ мэдээлэл, телевизийн 38 тодруулга ярилцлага, телевизийн 7 нэвтрүүлэгт холбогдох албан хаагч оролцож, мэдээ мэдээлэл нийтлүүлсэн. Нийт 252 цахим хуудас, 187 телевиз, 65 өдөр тутмын сонин, 6 радиотой хамтран ажиллаж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг нийтлэн нэвтрүүлж, сурталчилсан. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 9.8.96. Албан хэрэгцээнд www.able.mn дотоод сүлжээний e-office системийн хэрэглээг сайжруулж, албан хаагчдын мэдээллийн</p>	<ul style="list-style-type: none"> - Удирдлагын мэдээллийн нэгдмэл байдлыг хангаж, дотоод хяналтыг сайжруулах; - Албан хаагчдын ажлын төлөвлөлт, 	<p>Албан хаагчдын ажлын бүтээмж, гүйцэтгэлд ахиц гарсан байна.</p>	<p>ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА</p>	<p>Дотоод сүлжээний www.able.mn системд ажиллах талаар байгууллагын албан хаагчдад зөвлөмж өгч, цаг бүртгэлийн хурууны хээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан. Дотоод сүлжээний системийг удирдлагын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах, дотоод хяналт, албан хаагчдын ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийн явцыг хянах хэрэгсэл болгон ашиглаж хэвшсэн.</p>

технологийн мэдлэгийг дээшлүүлэх	гүйцэтгэлийн явцыг хянах, өдөр тутамд; - Цаг бүртгэлийн төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж, цаг ашиглалтад тавих хяналтыг дээшлүүлэх; - Жилдээ.	Гүйцэтгэлд тавих хяналт сайжирна.		Тайлангийн хугацаанд, байгууллагын дотоод сүлжээнд нэвтрэх эрхийг 15 албан хаагчид шинээр нээж, дотоод сүлжээнд албан хаагчид саадгүй харилцах боломжийг бүрдүүлэн, холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг тухай бүр хийж ажилласан. Газрын дотоод хэрэгцээнд ашиглагдах баримт материал, мэдээ мэдээлэл, зар мэдээ зэргийг дотоод сүлжээ ашиглан шуурхай хүргэн ажиллаж байна. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)
Арга хэмжээ 9.9.97. Байгууллагын хяналтын камер, хурлын өрөөний техник, тоног төхөөрөмжийн хэвийн жигд үйл ажиллагааг хангах	- Тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, хэвийн үйл ажиллагааг хангах; - Байгууллагын дотоод хяналтыг сайжруулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх; - Жилдээ.	Байгууллагын үйл ажиллагаа, дэг журам, сахилга, хариуцлага өндөржинө.	МТА, ЗХЗХ	Байгууллагын хяналтын камерын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шаардлагатай үед хяналтын камерын бичлэгийг эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгөх, үзүүлэх арга хэмжээг аван ажилласан. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)
ХӨТӨЛБӨР Х “Байгууллагын дотоод зохион байгуулалтыг сайжруулж, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах” хөтөлбөрийн хүрээнд:				
Арга хэмжээ 10.1.98. Газрын хуралдаан болон бусад хурлын бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хангаж ажиллах	- Хурлын бэлтгэлийг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл, гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг бэлтгэх, холбогдох хүмүүст хүргэх; - Хурлын тэмдэглэл хөтөлж, албажуулах; - Жилдээ.	Хурлын зохион байгуулалт хэвшиж, байгууллагын соёл төлөвшинө.	ЗХЗХ	ТӨБЗГ нь тайлант жилд газрын хуралдааныг 27 удаа, Даргын зөвлөлийн хурлыг 7 удаа, хэлтсийн нийт албан хаагчдын шуурхай хурлыг сар бүр нийт 12 удаа зохион байгуулж, газрын хэмжээнд нийт 46 удаагийн хурлын бэлтгэл, зохион байгуулалтын хэвийн ажиллагааг хангаж ажилласан. (“Бүрэн хэрэгжсэн” – 100%)
Арга хэмжээ 10.2.99. Нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж ажиллах	- Нэг цэгийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн аж ахуйн нэгжүүдэд өмчийн харилцаа болон тендертэй холбоотой мэдээ, мэдээллийг ил тод түргэн шуурхай хүргэх, цахим тендерт	Олон нийттэй харилцах харилцаа, мэдээлэл, лавлагааны үйлчилгээ нэг цэгт төвлөрч, иргэдэд чирэгдэлгүй,	ЗХЗХ	Байгууллагын “Нэг цэгийн үйлчилгээ”-ний танхимыг тохижуулж, иргэд, олон нийтэд үйлчилгээ үзүүлэх боломж нөхцлөөр хангаж ажилласан. “Нэг цэгийн үйлчилгээ”-гээр давхардсан тоогоор 6926 байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд үйлчилгээ үзүүлж, дэмжлэг үзүүлэн ажилласан. “Нэг цэгийн үйлчилгээ”-гээр үзүүлсэн үйлчилгээний үзүүлэлт, төрлөөр: - Мэдээлэл, зөвлөгөөг өгсөн - утсаар 2580 удаа, биечилж 1441 удаа; - Мэдэгдэл, тодруулга, саналын урилга хүргүүлсэн – 432; - Цахим системийн бүртгэл E-Токен код олгосон – 122; - Тендерийн материал худалдсан – 16;

	<ul style="list-style-type: none"> бүртгэх; - Бүртгэл тоо, баримт, мэдээлэлд анализ хийж, холбогдох газар, албан тушаалтанд мэдээлэх; - Сар бүр. 	<p>шуурхай үйлчлэх боломж бий болно.</p>		<ul style="list-style-type: none"> - Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтын гэрчилгээ олгосон (АЗ) – 1674; - Онлайн асуултад хариулсан 661 удаа. <p>(“Бүрэн хэрэгжсэн” – 100%)</p>
<p>Арга хэмжээ 10.3.100. Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт (ХХНЖ)-ыг шинэчлэн боловсруулж батлуулах, мөрдөн ажиллах</p>	<ul style="list-style-type: none"> - Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт (ХХНЖ) боловсруулах үйл ажиллагаатай холбоотой судалгаа хийх; - Гаргасан судалгаанд тулгуурлан ХХНЖ боловсруулах; - Баримт бичиг нягтлан шалгах комисс байгуулж, хуралдуулах, тухай бүрд; - Төрийн архивын нягтлан шалгах арга зүйн комиссоор хянуулах; - Газрын даргын тушаалаар батлуулж, мөрдүүлэх; - 2016 оны архивын материалыг албан хаагчдаас хүлээн авч, заавар, журмын дагуу архивын хадгаламжийн нэгж үүсгэх; - I улиралд. 	<p>Газрын үйл ажиллагаанд өдөр тутам үүсч хөтлөгдөж буй баримт бичгийг ангилал тодорхой болно. Бүлэглэх, хадгалах хугацаа нь оновчтой болсон байна.</p>	<p>ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА</p>	<p>Байгууллагын “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт” (ХХНЖ)-ын төслийг албан хаагчдаас санал авч, 57 нэрийн жагсаалттайгаар боловсруулав. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын төсөлд байнга хадгалах 26, түр хадгалах 31 баримт бичгийн нэр багтсан. Төслийг Захиргаа, хууль зүйн хэлтсийн даргаар хянуулан байгууллагын БНШК-ын хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэв. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Баримт бичиг нягтлан шалгах комисс”-ыг газрын даргын 2017 оны А/64 дүгээр тушаалаар байгуулсан. Тайлант хугацаанд ТӨБЗГ-ын 2016-2017 оны байнга хадгалах 617, түр хадгалах 3491 хадгаламжийн нэгжийг шинээр үүсгэн архивын данс бүртгэлд бүртгэн хадгалж байна.</p> <p>(“Хэрэгжих шатанд” – 70%)</p>
<p>Арга хэмжээ 10.4.101. Татан буугдсан байгууллага (ХААГ)-ын архивыг өмнө ажиллаж байсан албан хаагчдаас бүрэн хүлээн авах ажлыг зохион байгуулан хуулийн дагуу Архивын ерөнхий газарт хүлээлгэн өгөх</p>	<ul style="list-style-type: none"> - Архивын хадгаламжийн нэгжүүдийг хүлээлгэж өгөх бүртгэл, дансыг бэлтгэх; - Архивын баримт, хадгаламжийг нэгжийг үзэж хавтаслах; - Архивын Ерөнхий газарт данс, бүртгэлээр хүлээлгэж 	<p>Байгууллагын архивын бүрдүүлэлт, бүртгэл, данс бүрэн хөтлөгдөж, архивын нэгжийн баяжилт хийгдсэн байна. Татан буугдсан байгууллагын архивын нэгжүүд Төрийн архивт шилжсэн байна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Худалдан авах ажиллагааны газрын (татан буугдсан) архивын баримтын бүртгэлийг шинэчлэн гаргаж, байнга хадгалах 587, түр хадгалах 3200 хадгаламжийн нэгжийг цэгцэлж, нүүр бичилт хийсэн.</p> <p>(“Хэрэгжих шатанд” – 70%)</p>

	<p>өгөх; - I улиралд.</p>			
<p>Арга хэмжээ 10.5.102. Байгууллагад ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийг зохион байгуулах</p>	<p>- Албан бичгийн шийдвэрлэлтэд www.able.mn e-office дотоод сүлжээгээр дамжуулан хяналт тавих; - Хугацаатай албан бичгийг хууль, журамд заасан хугацаанд шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулах; - Шийдвэрлэгдээгүй албан бичгийн мэдээг удирдлагад танилцуулан шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллах; - Сар бүр.</p>	<p>Байгууллагын хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн стандарт, заавар, журмын хэрэгжилт хангагдсан байна.</p>	<p>3Х3Х</p>	<p>Тайлант хугацаанд, байгууллагад хариутай 3229, хариугүй 1782, нийт 5011 (Захиргаа, хууль зүйн хэлтэст 930, Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэст 1639, Төрийн өмчийн бүртгэл хяналтын хэлтэст 1864, Худалдан авах ажиллагааны хэлтэст 533) албан бичиг ирсэн. Ирсэн бичгийг байгууллагын дотоод сүлжээний www.able.mn цахим системд бүртгэж, удирдлагын заалтын дагуу хариуцсан албан хаагчдад хуваарилан шийдвэрлүүлж, хяналт тавин ажиллав. Хариутай 3229 албан бичгээс 2971 бичгийг шийдвэрлэж, хариу өгсөн бол 258 бичгийг шийдвэрлээгүй (хяналтанд 3, хугацаа хэтэрсэн 255) хүлээгдэж байна.</p> <p>("Хэрэгжих шатанд" – 70%)</p>
<p>Арга хэмжээ 10.6.103. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан, шийдвэрлэх асуудлаар санал боловсруулах</p>	<p>- Өргөдөл, гомдлыг судлан шийдвэрлэх арга замыг тодорхойлох; - Шийдвэрлэх саналыг боловсруулан удирдлагад танилцуулж шийдвэрлүүлэх; - Холбогдох иргэн, байгууллагад шийдвэрлэсэн хариуг хүргүүлэх; - Байгууллагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн судалгаа, мэдээнд хамруулах; - Сар бүр.</p>	<p>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.</p>	<p>3Х3Х, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА</p>	<p>2017 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 170 өргөдөл, гомдол (Захиргаа, хууль зүйн хэлтэст 78, Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэст 71, Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэст 17, Худалдан авах ажиллагааны хэлтэст 4) -ыг бичгээр хүлээн авч, байгууллагын дотоод сүлжээ www.able цахим системд бүртгэн, удирдлагын заалтын дагуу албан хаагчид хуваарилан шийдвэрлүүлсэн. Ирсэн өргөдөл, гомдлын 149 нь шийдвэрлэгдэж, 21 нь шийдвэрлэгдээгүй хүлээгдэж байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэсэн тухай хариуг хуулийн хугацаанд өгч ажиллав.</p> <p>Иргэдээс ТӨБЗГ-т ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг Даргын зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанд танилцуулан, хурлын тэмдэглэлээр хэлтэс, албан хаагчдад үүрэг, чиглэл өгч, иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх талаар авах арга хэмжээг тодорхой болгов.</p> <p>Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-өөр дамжуулан 2017 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт нийт 24 иргэн хандаж санал, хүсэлт, гомдол, ирүүлснийг хүлээн авч, бүртгэлд хамруулан шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллав. Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-өөр дамжуулан ирүүлсэн санал, хүсэлт гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай үзүүлсэн эсэхэд албан хаагчдын жилийн эцсийн Үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэлж, дүгнэхэд харгалзав. Төрийн өмчийн</p>

				бодлого, зохицуулалтын газарт Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-өөр дамжуулан иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, цаашид хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэж ажиллах талаар холбогдох албан хаагчдад үүрэг болгов. ("Хэрэгжих шатанд" – 70%)
Арга хэмжээ 10.7.104. Албан хаагчдын дунд зохион байгуулах олон нийтийн ажил, арга хэмжээг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Хэлтсүүдийн оролцоог хангасан комисс байгуулах; - Олон нийтийн ажил, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлах; - Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах; - Жилдээ. 	Албан хаагчийн чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрөөх, хамт олонч уур амьсгал, байгууллагын соёл бүрдсэн байна.	Олон нийтийн ажил зохион байгуулах комисс	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/16 дугаар тушаалаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын дунд олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах үүрэг бүхий комисс байгуулагдан ажиллав. Тайлангийн хугацаанд комиссын жилийн ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулан батлуулсан. Төлөвлөгөөнд нийт 21 ажил зохион байгуулахаар тусгагдсанаас 14 ажлыг зохион байгуулсан байна. Тухайлбал, Цагаан сарын золголтын арга хэмжээ, Ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх, Цэргийн баяр, Цасны баяр, Витамин Д-ийн ач холбогдол, Цус сэлбэлтийн ач холбогдол, Байгууллагын спортын өдөрлөг, Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Мод тарих аян, Мэдлэгээ хуваалцъя номын клуб, долоо хоног бүр спорт зааланд бие чийрэгжүүлэх зэрэг ажлыг зохион байгуулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан зарим ажлуудыг хэрэгжүүлэхээр бэлтгэж байгаа бөгөөд зохион байгуулалтын шатанд байна. ("Хэрэгжих шатанд" – 70%)
Арга хэмжээ 10.8.105. 2018 оны төсвийн төлөвлөгөөг Сангийн яаманд хянуулах	<ul style="list-style-type: none"> - Төсвийн төлөвлөлттэй холбоотой шаардлагатай баримт материалыг бэлтгэх; - 2018 оны төсвийн төслийг Сангийн яам, Ерөнхий сайдын ажлын албанд хүргүүлэх; - III-ҮI сард. 	2018 оны төсвийн төлөвлөлт хийгдэж, хянагдсан байна.	ЗХЗХ	ТӨБЗГ-ын 2018 оны төсвийг 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгахаар Төсвийн Ерөнхийлөн захирагчид хүргүүлж, улмаар Сангийн яаманд хянуулсан. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдсанаар ТӨБЗГ-ын 2018 оны төсөв 1.9 тэрбум төгрөгөөр батлагдаж, 2018 оны төсвийн зардлын хуваарийг Төсвийн Ерөнхийлөн захирагчид хүргүүлэн батлуулсан. ("Бүрэн хэрэгжсэн" – 100%)
Арга хэмжээ 10.9.106. Сар бүрийн 05-ны өдрийн дотор нийгмийн даатгалын тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг гаргах	<ul style="list-style-type: none"> - Холбогдох тайланг хуульд заасан хугацаанд гаргах; - Тайланг Нийгмийн даатгалын байгууллага, Ерөнхий сайдын нягтланд хүргүүлэх; - Сар бүрд. 	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт шаардлагад нийцсэн тайлан, тэнцлийг гаргасан байна.	ЗХЗХ, Ахлах нягтлан бодогч Ж.Мөнхтүвшин	Байгууллагын албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг сар бүрийн 5 –ны өдрийн дотор НД7, НД8 батлагдсан маягтын дагуу гарган нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэн баталгаажуулах арга хэмжээ авч, албан хаагчийн дэвтэрт бичилт хийлгэж хэвшсэн. Санхүү эдийн засгийн сайдын 2003 оны 49 дугаар тушаалаар батлагдсан загварын дагуу төсвийн гүйцэтгэлийн зарлагын сарын мэдээг сар бүрийн 02-ны өдрийн дотор гарган Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж байна. ("Бүрэн хэрэгжсэн" – 100%)
Арга хэмжээ 10.10.107. Ашиглалтын хугацаа	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын "Өмч хамгаалах байнгын 	Эд хөрөнгийн бүрэн бүтэн	Нярав С.Цэрэндорж	Байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийг ТӨБЗГ-ын 2017 оны А/40 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулж

<p>дуусан чанарын шаардлага хангахгүй болсон хөрөнгийн жагсаалт гарган, эд хөрөнгийн бүртгэлийг шинэчлэх</p>	<p>зөвлөл"-ийг томилох; - Ашиглалтын хугацаа дуусан цаашид ашиглагдахгүй болсон эд хөрөнгийн жагсаалт гаргах; - "Өмч хамгаалах байнгын зөвлөл", Даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах; - Эд хөрөнгийн бүртгэлээс хасч холбогдох гүйлгээг хийх; - Албан хаагч бүрт эд хөрөнгийн бүртгэл, ашиглалтын картыг хөтлөх; - Эд хөрөнгийн бүртгэл, кодчиллыг шинэчлэх; - I сард</p>	<p>байдалд хяналт тавих боломж бүрдэнэ.</p>		<p>байна.</p> <p>Ашиглалтын хугацаа дуусан цаашид ашиглагдахгүй болсон эд хөрөнгийн жагсаалтыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 28, 57 дугаар тогтоолоор нийт 105.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах зөвшөөрөл гаргуулсан. Уг шийдвэрийн дагуу байгууллагын санхүүгийн тайлангаас хассан.</p> <p>Байгууллагын 395,172,967.2 төгрөгийн 1200 гаруй эд хөрөнгийг коджуулан, албан хаагч бүрээр эд хөрөнгийн бүртгэл, ашиглалтын картыг шинэчлэн хөтлөх ажлыг хийж дуусгав.</p> <p>("Бүрэн хэрэгжсэн" – 100%)</p>
<p>Арга хэмжээ 10.11.108. Байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангахад шаардлагатай бараа, материалыг татан авч, хуваарилах</p>	<p>- Бичиг хэргийн бараа, материалын нийлүүлэгчтэй холбогдох хууль, журамд заасны дагуу гэрээ хийх; - Бараа, материалын захиалга, татан авалт, хангалт, хуваарилалт хийх; - Төсөв, тооцоог төлөвлөж, тайлан гаргах; - Улирал бүрд.</p>	<p>Байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа хангагдана.</p>	<p>ЗХЗХ, Нярав С.Цэрэндорж</p>	<p>"Ган үзэг" бөөний төв, "Микер" ХХК, Архивын Ерөнхий газар, Монголын хараагүйчүүдийн үндэсний төв, "Гурван цагийн өнгө" ХХК, МУИС-ийн хэвлэх үйлдвэр, "Таван богд" ХХК, "Билү Йирт" ХХК зэрэг аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангахад шаардлагатай бараа, материалын нийлүүлэлт, хангалтыг гэрээний үндсэн дээр гүйцэтгэв. 2017 онд бичиг хэргийн зардалд нийт 25.3 сая төгрөгийн, тээвэр шатахууны зардалд 12.9 сая төгрөгийн зардал гаргаж ажилласан нь төлөвлөгдсөн зардал хэтрээгүй дүнтэй байна. Бараа материалуудыг албаны хэрэгцээ шаардлагатай уялдуулан нийт 40 удаагийн татан авалт хийж, агуулахад нөөцөлсний дүнд холбогдох журмын дагуу ажилтнуудад нийт 310 ширхэг шаардах хуудсаар бараа, материалын олголт хийж ажиллав. ("Бүрэн хэрэгжсэн" – 100%)</p>
<p>Нийт: 10 хөтөлбөр, 108 арга хэмжээ</p>				

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТАНИЛЦУУЛГА

(Газрын даргын ҮДГ буюу байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийт ажлаар)

Төсвийн шууд захирагчийн Үр дүнгийн гэрээ буюу байгууллагын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан **108 арга хэмжээний** хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар гарган дүгнэв. Хэрэгжилтийн явцын дүнгээс дүгнэхэд, 2017 онд төлөвлөсөн нийт 108 зорилт (арга хэмжээ)-ын хэрэгжилтийн явц дунджаар **86.9 хувийн** гүйцэтгэлтэй байна. Хэрэгжилтийн дүнг тооцоходоо Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалыг баримтлан дүгнэв.

Хэрэгжилтийн явцын дүн

Д/д	Хэрэгжилтийн явц	Заалтын тоо
1	Нийт хэрэгжүүлэх арга хэмжээ	108
2	Үүнээс: “Бүрэн хэрэгжсэн” – 100 %	77
3	“Хэрэгжих шатанд” – 70 %	22
4	“Хэрэгжилт хангалтгүй” – 30 %	5
5	“Хэрэгжээгүй” – 0 %	4
6	“Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”	0
7	Хэрэгжилтийн дундаж хувь	86.9

ТАНИЛЦСАН:

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ,
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э.ЭРДЭНЭХИШИГ

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ

2017 оны 12 сарын 25 өдөр